

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-140-Р ДҮРМИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">Нисэхийн <u>аюулгүйн хамгаалалтын</u> үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт (Шинэчлэгдэж байгаа) /31 хуудас/2013 оны NZ amend.6</p>	<p align="center">НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН <u>ҮЙЛЧИЛГЭЭНИЙ</u> БАЙГУУЛЛАГА, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /28 хуудас (үндсэн дүрэм-39 хуудастай байсан)/1998 оны NZ original</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>140.1. Хамрах хүрээ <u>Энэ Дүрэм нь аюулгүйн хамгаалалттай аэродром, эсхүл аюулгүйн хамгаалалттай навигацййн байгууламжид нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.</u></p>	<p>140.1 Зорилго (a) <u>Энэхүү дүрмийн зорилго нь нисэх буудал болон агаарын навигацййн тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээ эрхлэх Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллага (цаашид НАБҮБ гэх)-ыг гэрчилгээжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааны журмыг тогтооход оршино.</u></p>	<p>-“Аюулгүй байдлын хамгаалалт тогтоосон аэродром, эсхүл навигацййн байгууламжид НАБ-ын хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх” гэж өөрчлөгдсөн</p>
<p>140.3. Нэр томьёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.</p>	<p>140.3 Тодорхойлолт</p>	<p>-Нэр томьёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p>140.5. Гэрчилгээний шаардлага Энэ Дүрмийн дагуу олгосон нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын (цаашид НАХҮБ гэх) гэрчилгээний эрхийн хүрээ болон нөхцөлөөс гадуур аливаа этгээд <u>аюулгүйн хамгаалалттай аэродром, эсхүл аюулгүйн хамгаалалттай навигацййн байгууламжид</u> нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхгүй.</p>	<p>140.5 Үндсэн шаардлага (a) <u>Нисэх буудлын болон агаарын навигацййн тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээ эрхлэхийг хүсэж өргөдөл гаргасан хуулийн этгээдэд Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх)-аас энэ дүрмийн дагуу гэрчилгээ олгоно.</u></p>	<p>-<u>Security designated- гэдгийг орхигдуулснаас бүх (16) Нисэх буудлыг гэрчилгээжүүлж, хавтгайруулсан</u></p>
<p>140.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24140/01 маягтыг бөглөж, дараах баримт бичгийн хамт <u>Даргад</u> хүргүүлнэ: (1) 140.61-д шаардсан Ерөнхий заавар; (2) зохих төлбөрийн баримт.</p>	<p>140.7 Өргөдөл гаргах (a) Энэ дүрмийн дагуу нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь ИНД-140/01 маягтыг бөглөж дараах баримт бичгийн хамт ИНЕГ-т ирүүлнэ: 1/ өргөдөл, төлбөрийн баримт; 2/ энэ дүрмийн 140.61-д заасан Үйл ажиллагааны заавар.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -“ИНЕГ” гэснийг “Дарга” гэж өөрчлөгдсөн.</p>
<p>140.9. Гэрчилгээ олгох Дарга дараах тохиолдолд НАХҮБ-ын гэрчилгээ олгоно, хэрэв:</p>	<p>140.9 Гэрчилгээ олгох (a) ИНЕГ-ын дарга нь НАБҮБ-ын гэрчилгээг дараах нөхцөлд олгоно:</p>	

<p>(1) хүсэлт гаргагчийн 140.51-д шаардсан удирдах ажилтан нь тохирох зөв хүн бол;</p> <p><u>(2) хүсэлт гаргагч нь:</u></p> <p><u>(i) НАХҮБ бол; эсхүл</u></p> <p><u>(ii) аюулгүйн хамгаалалттай аэродром, эсхүл аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн аэродром, эсхүл навигацийн байгууламжид нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх бол;</u></p> <p>(3) хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь В Бүлгийн шаардлага хангасан бол;</p> <p>(4) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхолд харшлахгүй бол.</p>	<p>1/ өргөдөл гаргагчийн ажилтан, албан тушаалтан нь энэ дүрмийн 140.51-д заасан шаардлагыг хангасан;</p> <p>2/ өргөдөл гаргагч нь энэ дүрмийн Б Бүлэгт заасан шаардлагуудыг хангасан;</p> <p>3/ гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд харшлахгүй байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан.</p>
<p>140.11. Гэрчилгээ эзэмшигчийн <u>гүйцэтгэх ажил, үүрэг</u></p> <p>(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавартаа заасан байрлал бүрд дараах ажил, үүргийг гүйцэтгэнэ:</p> <p>(1) аюулгүйн хамгаалалттай аэродромд:</p> <p>(i) олон улсын болон орон нутгийн зорчигч үйлчилгээний агаарын хөлгийн зорчигч, хөлгийн баг, тээшинд аюулгүйн үзлэг хийх, эсхүл Даргын үзлэг хийхийг шаардсан бусад үйлчилгээнд аюулгүйн үзлэг хийх;</p> <p>(ii) шаардлагатай бол, агаарын хөлгийг шалгах;</p> <p>(iii) аэродромын аюулгүйн хамгаалалтын эргүүл хийх;</p> <p><u>(iv) Даргын шаардсан, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд байгаа, эсхүл нэвтрэх гэж байгаа этгээд, эд зүйл, бодис, эсхүл тээврийн хэрэгсэлд, Даргын баталсан аюулгүйн үзлэгийн тусгай хэлбэр, эсхүл аргачлалын дагуу аюулгүйн үзлэг болон шалгалт хийх;</u></p> <p>(2) хамгаалалттай навигацийн байгууламжид эргүүл хийх;</p> <p>(3) иргэний нисэх болон түүнд ажиллагсад, эсхүл түүний үйлчилгээг авч байгаа этгээдийг хамгаалахтай холбоотой аюулгүйн хамгаалалтын арга техник, тогтолцоо, хэрэгсэл, практик дадал болон журмыг хянах, судлах, түүний талаар тогтмол мэдээлэлтэй байх;</p> <p><u>(4) өөрийн ажил үүргийг энэ Дүрмийн дагуу илүү үр дүнтэй гүйцэтгэх зорилгоор цагдаа, төрийн байгууллага, нисэх буудлын эрх бүхий байгууллага, үйл ажиллагаа эрхлэгч болон бусад улсын нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ хариуцсан эрх бүхий байгууллага холбогдох олон улсын байгууллагатай хамтран ажиллах.</u></p>	<p>140.11 Гэрчилгээ эзэмшигчийн <u>эрх, үүрэг</u></p> <p>(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах эрх, үүрэгтэй:</p> <p>1/ нисэх баг, зорчигч, тэдгээрийн гар тээш, тээш, ачаанд аюулгүй байдлын үзлэг хийх;</p> <p>2/ шаардлагатай үед агаарын хөлөгт үзлэг хийх;</p> <p>3/ аэродромын хамгаалалтыг хариуцаж, аюулгүй байдлын эргүүл хийх;</p> <p>4/ нисэх буудлын хамгаалагдсан болон хориотой бүсүүдэд нэвтрэх хүн, тэдгээрийн авч яваа эд зүйлс болон тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалт хийх;</p> <p>5/ навигацийн тоног төхөөрөмжийн хамгаалалтыг хариуцах;</p> <p>6/ дээрх зүйлүүдэд заасан үйл ажиллагааг эрхлэхдээ ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг гадаад, дотоодын</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.4-өөр нэмэлтээр орсон</p> <p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>

<p>(b) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан, НАХҮБ нь Монгол Улсын Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөрт заасан ажил, үүргийг гүйцэтгэнэ.</p> <p><u>(c) Даргад Хуулиар олгосон эрхийг хэрэгжүүлэх зорилгоор, энэ Дүрмийн дагуу эрх олгогдсон этгээд нь Даргын шаардлагатай гэж үзсэн бүс, эсхүл талбайд нэвтрэх хяналт тавих, эсхүл хориглох арга хэмжээг авч болно. (шилжилт)</u></p>	<p>байгууллагуудтай хамтарч ажиллах.</p> <p>(b) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)-д зааснаас гадна иргэний нисэхийн аюулгүй байдлын журам /үндэсний хөтөлбөр/-д заасан үүргийг хүлээнэ.</p>	<p>- Part 19-өөс шилжүүлсэн</p>
<p>140.13. Гэрчилгээний хугацаа</p> <p>(a) НАХҮБ-ын гэрчилгээг <u>5 жил хүртэл</u> хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.</p> <p>(b) НАХҮБ-ын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, эсхүл түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд, хүчинтэй хэвээр байна.</p> <p>(c) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүйд тооцсон тохиолдолд, гэрчилгээг Даргад хураалгана.</p> <p>(d) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээг түдгэлзүүлсэн бол зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг <u>Даргад</u> хүргүүлнэ.</p>	<p>140.13 Гэрчилгээний хугацаа</p> <p>(a) ИНЕГ-аас НАБУБ-ын гэрчилгээг 3 хүртэлх жилийн хугацаагаар олгоно.</p> <p>(b) Гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дуусах, эсхүл ИНЕГ-аас үйл ажиллагааг нь түр түдгэлзүүлсэн болон бүрмөсөн зогсоох хүртэл хүчин төгөлдөр байна.</p> <p>(в) Гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл үйл ажиллагааг нь тодорхой хугацаагаар түдгэлзүүлсэн буюу бүрмөсөн зогсоосон тохиолдолд эзэмшигч нь гэрчилгээг ИНЕГ-т хураалгана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -Гэрчилгээний хугацааг 3 хүртэл жил - 5 жил болгосон</p>
<p>140.15. Гэрчилгээг сунгах</p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигч нь НАХҮБ-ын гэрчилгээг сунгуулах хүсэлтийг САА 24140/01 маягтын дагуу гаргаж <u>Даргад</u> хүргүүлнэ.</p> <p>(b) Гэрчилгээг сунгуулах хүсэлтийг гэрчилгээнд заасан хугацаанд, хэрэв сунгах хугацаа заагаагүй бол, гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө гаргана.</p>	<p>140.15 Гэрчилгээний хугацааг сунгуулах</p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигч нь НАБУБ-ын гэрчилгээний хугацааг сунгуулах тухай өргөдлийг түүний хүчинтэй хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө ИНЕГ-140/01 маягтын дагуу гаргаж хамт ИНЕГ-т ирүүлнэ.</p> <p>(b) ИНЕГ нь Гэрчилгээ эзэмшигчийн гаргасан өргөдлийг үндэслэн гэрчилгээг 3 хүртэлх жилийн хугацаагаар сунгаж болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>В Бүлэг-Гэрчилгээжүүлэлтийн шаардлага</p> <p>140.51. Ажилтанд тавих шаардлага</p> <p>(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар ажиллуулна:</p> <p>(1) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагааг санхүүжүүлэх ба энэ Дүрэмд заасан шаардлагын дагуу гүйцэтгэж чадахаа <u>хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй, Гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон удирдах ажилтан;</u></p> <p>(2) дараах удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд:</p> <p>(i) хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах үүрэг хариуцлага хүлээсэн;</p>	<p>Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА</p> <p>140.51 Ажилтан, албан тушаалтанд тавигдах шаардлага</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь дараах албан тушаалтан, ажилтантай байна:</p> <p>1/ нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа энэ дүрмийн дагуу гүйцэтгэгдэж, санхүүжиж байгааг бататгах эрх бүхий удирдах албан тушаалтан;</p> <p>2/ аюулгүй байдлын үзлэг, шалгалт хийх, хяналт тавих сургалтанд хамрагдаж, үнэмлэхжсэн, гүйцэтгэх ажилтантай байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(ii) Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээсэн;</p> <p>(3) 140.61(а)(7)-д дэлгэрэнгүй заасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг төлөвлөх, шалгах, хянах болон гүйцэтгэх <u>хангалттай тооны ажилтан</u>.</p> <p>(b) <u>Хүсэлт гаргагч нь</u>:</p> <p>(1) тухайн ажил үүрэг гүйцэтгэхээр хүсэлт гаргасан этгээдийн ур чадварт суурь үнэлгээ хийх журам болон НАХ-ын ажилтны ажлын байрны шаардлагыг дараах шалгуурыг харгалзан тогтооно:</p> <p>(i) боловсрол;</p> <p>(ii) харилцааны чадвар;</p> <p>(iii) зан харьцаа;</p> <p>(iv) туршлага;</p> <p>(v) эрүүл мэнд;</p> <p><u>(2) ажилтнуудаас, НАХ-ын ажилтан болох этгээдийг томилно;</u></p> <p>(3) НАХ-ын ажилтныг сургах болон ур чадварыг хадгалах журмыг тогтооно;</p> <p><u>(4) 140.61(а)(7)-д дэлгэрэнгүй заасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг төлөвлөх шалгах, хянах болон гүйцэтгэх ажилтанд түүний эрхийн хүрээг тодорхойлсон баримт бичиг олгоно.</u></p>	<p>(б) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах баримт бичгийг боловсруулсан байна:</p> <p>1/ аюулгүй байдлын ажилтны ажлын байрны тодорхойлолт;</p> <p>2/ аюулгүй байдлын ажилтныг сонгон шалгаруулах журам;</p> <p>3/ аюулгүй байдлын ажилтныг сургах, давтан сургах журам.</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан.</p>
<p>140.53. Үйл ажиллагааны <u>журам</u> тогтоох</p> <p>(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тогтоосон аэродромд аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх бол, Хавсралт А-д заасан шаардлагыг хангахад шаардлагатай журмыг тогтооно.</p> <p>(b) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тогтоосон навигацийн байгууламжид аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх бол, А.12 (d)-д заасан шаардлагыг хангахад шаардлагатай журмыг тогтооно</p>	<p>140.53 Үйл ажиллагааны <u>заавар</u></p> <p>(a) Өргөдөл гаргагч нь нисэх буудлын аюулгүй байдлыг хангах үйлчилгээ эрхлэх бол энэ дүрмийн Хавсралт А-д заасан шаардлагад нийцсэн Үйл ажиллагааны зааврыг боловсруулсан байна.</p> <p>(б) Өргөдөл гаргагч нь агаарын навигацийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээ эрхлэх бол энэ дүрмийн Хавсралт А12-ын (в)-д заасан шаардлагад нийцсэн журмыг боловсруулсан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -Procedure-заавар гэж орчуулсныг журам болгосон</p>
<p>140.55. Баримт бичиг</p> <p>(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг дэмжихэд чиглэсэн бүх баримт бичгийг авч ашиглах боломжтой хэлбэрээр хангадаг болохыг бататгах журмыг тогтооно.</p> <p>(b) Энэ зүйлийн (а)-д заасан баримт бичигт дараах баримт бичиг багтсан байна:</p> <p>(1) холбогдох бүх хууль тогтоомж;</p> <p>(2) нисэхийн аюулгүйн хамгаалалттай холбоотой олон улсын</p>	<p>140.55 Баримт бичиг</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь аюулгүй байдлын үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай баримтын бичгийн бүрдүүлэлттэй холбогдсон журмыг боловсруулна.</p> <p>(б) Энэ зүйлийн (а)-д заасан баримт бичигт дараах зүйлс багтана:</p> <p>1/ холбогдох хууль, эрхийн актууд;</p> <p>2/ нисэхийн аюулгүй байдлын талаарх олон улсын стандарт,</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>техникийн заавар, эсхүл мэдэгдэл;</p> <p>(3) <u>Даргаас тухайн</u> гэрчилгээ эзэмшигчид олгосон баримт бичиг;</p> <p>(4) гэрчилгээ эзэмшигчийн <u>Ерөнхий заавар</u>.</p> <p>(c) Хүсэлт гаргагч нь, энэ зүйлийн (a)-д заасан, дараах шаардлагыг бататгах баримт бичгийн хяналтын журамтай байна:</p> <p>(1) тухайн баримт бичгийг гаргахын өмнө холбогдох ажилтан хянаж баталдаг байх;</p> <p>(2) холбогдох баримт бичгийн хүчинтэй хувь нь, ажилтан тухайн баримт бичгийг ашиглахад хэрэгтэй байрлал бүрд бэлэн байх;</p> <p>(3) хугацаа нь дууссан баримт бичгийг олгох, эсхүл ашиглах бүх цэгээс нэн даруй хурааж авдаг байх;</p> <p>(4) баримт бичигт орсон өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, баталдаг байх;</p> <p>(5) баримт бичгийн хүчинтэй хувь нь танигддаг байх;</p> <p><u>(6) байгууллагын Ерөнхий зааварт, тухайн үйлчилгээ үзүүлэгч, түүний үйлчилгээ, журам болон байгууламжийн тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар өөрчлөлт хийдэг байх.</u></p> <p>(d) Хүсэлт гаргагч нь Ерөнхий зааврын хувийг 140.61 (a)(5)-д заасан байрлал бүрд байлгаж, хөтлөх журмыг тогтоосон байна.</p>	<p>заавар, зөвлөмж;</p> <p>3/ <u>Иргэний нисэхийн ерөнхий газраас</u> гэрчилгээ эзэмшигчид олгосон баримт бичиг;</p> <p>4/ гэрчилгээ эзэмшигчийн <u>Үйл ажиллагааны заавар</u>.</p> <p>(в) Өргөдөл нь дараах зүйлүүдийг багтаасан баримт бичигт хяналт тавих журмыг боловсруулна:</p> <p>1/ баримт бичгийг олгохоос өмнө холбогдох хүмүүсээр хянуулж батлуулах;</p> <p>2/ тухайн баримт бичгийг эрх бүхий хүмүүс ашиглах боломж, нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>3/ хугацаа нь дууссан баримт бичгийн олголт болон ашиглалтыг нэн даруй зогсоох;</p> <p>4/ баримт бичигт оруулах өөрчлөлтийг холбогдох хүмүүсээр хянуулж, баталгаажуулах;</p> <p>5/ Үйл ажиллагааны зааварт өөрчлөлт оруулах тохиолдолд үзүүлж буй үйлчилгээ, журам, хэрэгслийг алдагдуулахгүй байх.</p> <p>(г) Өргөдөл гаргагч нь ИНД-140.61-ийн (a) 5/-д заасан байрлал бүрд Үйл ажиллагааны зааврын хувийг байршуулах журмыг боловсруулна.</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p>140.57. Бүртгэл хөтлөх</p> <p>(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн нийцлийг бататгахад шаардлагатай, бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах болон хөтлөх журмыг тогтоосон байна.</p> <p>(b) Хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:</p> <p>(1) түүний НАХ-ын ажилтны туршлага, мэргэшил, ур чадвар, сургалт, эрүүл мэндийн үнэлгээ болон хүчинтэй зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан бүртгэл хөтлөх;</p> <p>(2) дараах шаардлагыг хангасан болохыг бататгах:</p> <p><u>(i) бүх бүртгэл нь гаргацтай бөгөөд байнгын, арилдаггүй байх;</u></p> <p><u>(ii) энэ зүйлийн (b)(1)-д шаардсан бүртгэлийг, гэрчилгээ эзэмшигч тухайн этгээдэд олгосон эрхийг зогсоосон өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хадгалдаг байх;</u></p>	<p>140.57 Бүртгэл</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь энэ бүлэгт заасан бүртгэлийг хөтлөх, индексжүүлэх, хадгалах болон засвар оруулах журмыг боловсруулна.</p> <p>(б) Өргөдөл гаргагч нь :</p> <p>1/ өөрийн ажилтны дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлнө (үүнд тэдний мэргэжил, туршлага, ур чадвар, сургалт, эрүүл мэндийн байдал);</p> <p>2/ бүртгэл нь хууль ёсны болон тогтмол байна;</p> <p>3/ албан тушаалтны бүртгэлийг тухайн ажилтан ажлаас халагдсанаас хойш 2 жил, бусад бүртгэлийг мөн 2 жилийн хугацаанд хадгална.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

(iii) энэ зүйлийн (b)(1)-д шаардсанаас бусад бүртгэлийг 2 жилийн хугацаанд хадгалдаг байх.

140.59. Дотоод чанар баталгаажуулалт

- (a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрмээр шаардсан журам нь шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн байна.
- (b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаасан байна:
- (1) хүсэлт гаргагчийн байгууллагын зорилго болон түүний үйлчлүүлэгчийн хүсэл эрмэлзэл, хэрэгцээнд тохирсон Аюулгүйн хамгаалалтын бодлого болон аюулгүйн хамгаалалтын бодлогын журам;
 - (2) тухайн тогтолцоонд оршиж байгаа түүний, эсхүл хүндрэлтэй асуудал, эсхүл түүний боломжит бодит шалтгааныг тогтоох зорилгоор гэмтэл, зөрчлийн тайлан болон ажилтан, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг багтаасан, Чанарын үзүүлэлтэд мониторинг хийдэг болохыг бататгах журам;
 - (3) тухайн тогтолцоонд илэрсэн хүндрэлтэй асуудлыг залруулдаг болохыг бататгах, Залруулах арга хэмжээний журам;
 - (4) тухайн тогтолцоонд илрүүлсэн хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг арилгадаг болохыг бататгах Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;
 - (5) хүсэлт гаргагчийн байгууллага нь өөрийн Ерөнхий зааварт заасан журамтай нийцэж байгаа болон аюулгүйн хамгаалалтын бодлогод тусгасан зорилтод хүрснийг шалгах, Чанарын дотоод аудитын хөтөлбөр;
 - (6) шаардлагатай тохиолдолд статистикийн дүн шинжилгээний ашиглалтыг багтаасан, дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохирол болон үр дүн нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах удирдлагын дүгнэлт хийх журам;
 - (7) дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь аюулгүйн хамгаалалтад нөлөөлөх асуудлаар Гүйцэтгэх захиралтай шууд харьцах эрхтэй болохыг бататгах журам.
- (c) Аюулгүйн хамгаалалтын бодлогын журам нь аюулгүйн хамгаалалтын бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгодог, хэрэгжүүлдэг болон мөрддөг болохыг бататгана.
- (d) Залруулах арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байна:
- (1) оршиж байгаа хүндрэлтэй асуудлыг залруулах;
 - (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах зорилгоор

140.59 Чанар баталгаажуулалтын дотоод тогтолцоо

- (a) Гэрчилгээ эзэмшигч нь ИНД-140-д хамаарах журмууд хэрхэн мөрдөгдөж байгаа буюу үйл ажиллагаанд хэрхэн нийцэж байгаа эсэхийг бататгах зорилго бүхий чанар баталгаажуулалтын дотоод тогтолцоотой байна.
- (b) Чанар баталгаажуулалтын дотоод тогтолцоо нь дараах журмуудад үндэслэнэ:
- 1/ байгууллагын зорилго болон үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд үндэслэсэн аюулгүй байдлын бодлогын журам;
 - 2/ дутагдал болон зөрчлийн тайлан, ажиллагсдын ба үйлчлүүлэгч нарын талаарх мэдээллийг хяналтын үйл ажиллагаанд ашиглах журам;
 - 3/ дутагдлыг арилгах арга хэмжээний журам;
 - 4/ урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
 - 5/ чанарын хяналтын хөтөлбөр;
 - 6/ удирдлагын хяналтын журам;
 - 7/ чанар баталгаажуулалтын дотоод тогтолцооны талаар үүрэг хүлээсэн албан тушаалтнаас нисэхийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар байгууллагын даргатай харилцах журам.
- (в) Энэ зүйлийн (б)-д заасан журмууд нь ойлгомжтой, байгууллагын бүх түвшинд хэрэгжихүйц байна.
- (г) Дутагдлыг арилгах арга хэмжээний журамд дараах зүйлийг тусгасан байна:
- 1/ дутагдлыг хэрхэн арилгах талаар;
 - 2/ дутагдлыг арилгах арга хэмжээний үр дүнд холбогдох

-Орчуулга,
найруулга зассан

<p>залруулах арга хэмжээг эргэн шалгах;</p> <p>(3) удирдах ажилтан залруулах арга хэмжээний үр дүнг үнэлэх.</p> <p>(е) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байна:</p> <p>(1) хүндрэл үүсэж болох асуудлыг залруулах;</p> <p>(2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах зорилгоор, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эргэн шалгах;</p> <p>(3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд, энэ Дүрмийн дагуу шаардсан журамд өөрчлөлт оруулах;</p> <p>(4) удирдах ажилтан урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг үнэлэх.</p> <p>(f) Чанарын дотоод аудитын хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) аудит хийгдэх ажиллагааны шинж чанартай уялдуулан аудитын давтамж болон байрлалыг заасан байх;</p> <p>(2) тухайн аудитыг сургалтад хамрагдсан бөгөөд аудит хийгдэж байгаа ажиллагаанд шууд хариуцлага хүлээдэг этгээдээс хамааралгүй ажилтан хийдэг болохыг бататгадаг байх;</p> <p>(3) аудитын үр дүнг, аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтанд болон дотоод аудит хариуцсан менежерт мэдээлдэг болохыг бататгадаг байх;</p> <p>(4) хэрэв тухайн аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол, аудит хийгдсэн тухайн ажиллагааг хариуцсан ажилтнаас урьдчилан сэргийлэх эсхүл залруулах арга хэмжээ авахыг шаарддаг байх;</p> <p>(5) авч хэрэгжүүлсэн залруулах, эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд дүгнэлт хийх зорилгоор эргэн шалгах аудит хийдэг болохыг бататгадаг байх.</p> <p>(g) Удирдлагын дүгнэлт хийх журам нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) тухайн тогтолцооны байнгын үр дүнтэй байх хэрэгцээ шаардлагыг авч үзсэний үндсэн дээр, чанар баталгаажуулалтын тогтолцооны удирдлагын дүгнэлт хийх давтамжийг тодорхойлсон байх;</p> <p>(2) тухайн чанар баталгаажуулалтын тогтолцоонд үнэлгээ хийх менежерийг тогтоосон байх;</p> <p>(3) тухайн дүгнэлтийн үр дүнг дүгнэж, бүртгэл хөтөлдөг болохыг бататгасан байх.</p>	<p>журмуудад хэрхэн өөрчлөлт хийх талаар;</p> <p>3/ дутагдлыг арилгах арга хэмжээний үр дүнг үнэлэх талаар.</p> <p>(д) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах зүйлүүдийг тусгасан байна:</p> <p>1/ байгууллагын үйл ажиллагаа зөв явагдаж байгааг баталгаажуулан, урьдчилан сэргийлэх ажиллагааг дагаж мөрдөх талаар;</p> <p>2/ урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнд ИНД-140-д заасан журамд өөрчлөлт оруулах талаар;</p> <p>3/ аливаа урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнг удирдлагаас үнэлэх талаар.</p> <p>(е) Чанарын хяналтын хөтөлбөрт дараах зүйлүүдийг тусгасан байна:</p> <p>1/ аудит хийгдэх объект, давтамж;</p> <p>2/ аудит хийх эрх бүхий албан тушаалтан нь сургалтанд хамрагдсан, мөн тухайн үйл ажиллагааны талаар ямар нэгэн хариуцлага хүлээдэггүй байх;</p> <p>3/ аудитын дүнг мэдээлэх журмын талаар;</p> <p>4/ аудитын явцад дутагдал илэрсэн тохиолдолд дутагдлыг арилгах арга хэмжээ авах талаар;</p> <p>5/ аливаа урьдчилан сэргийлэх болон дутагдал арилгах үйл ажиллагааны үр дүнд аудит хийх талаар.</p> <p>(ж) Удирдлагын хяналтын журамд:</p> <p>1/ чанар баталгаажуулалтын дотоод тогтолцооны идэвхитэй ажиллагааг хангах үүднээс удирдлага болон зохион байгуулалтад хяналт тавих үечлэлийг заасан байна;</p> <p>2/ чанар баталгаажуулалтын дотоод тогтолцоонд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтныг тодорхойлсон байна;</p> <p>3/ аудитын үр дүнг үнэлж дүгнэх ба тайлан гаргах талаар заасан байна.</p>	
<p>140.61. Байгууллагын <u>Ерөнхий заавар</u></p> <p>(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан <u>Ерөнхий зааврыг Даргад</u> хүргүүлэх үүрэгтэй:</p>	<p>140.61 Байгууллагын <u>Үйл ажиллагааны заавар</u></p> <p>(а) Өргөдөл гаргагч нь дараах зүйлийг тусгасан <u>Үйл ажиллагааны зааврыг</u> боловсруулж <u>ИНЕГ</u>-т ирүүлнэ:</p>	

(1) Ерөнхий заавар нь дараах шаардлагыг хангасныг баталж, байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:

(i) тухайн байгууллагыг тодорхойлсон ба энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах арга хэлбэрийг харуулсан байх;

(ii) тухайн байгууллагын ажилтнууд байнга дагаж мөрддөг байх;

(2) 140.51(а)(1) болон (2)-т шаардсан ажилтны нэр болон албан тушаал;

(3) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Даргатай шууд харилцах асуудлыг багтаасан, энэ зүйлийн (а)(2)-т заасан этгээдийн үүрэг, хариуцлага;

(4) энэ зүйлийн (а)(2)-т заасан ажилтан болон хяналтын ажилтны хариуцлагын хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;

(5) нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байгаа байгууллагын бүх байрлал болон байрлал бүрийн байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(6) энэ зүйлийн (а)(5)-д заасан байрлал бүрд шаардлагатай, тухайн байгууллагын ажиллагсдын бүтцийн хураангуй;

(7) байрлал бүрд үзүүлэх нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл;

(8) эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлтийн хамрах хүрээ болон Хавсралт А.22-т шаардсан бие бялдрын үнэлгээний аргын дэлгэрэнгүй мэдээлэл;

(9) дараах дүрэмд шаардсан, хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл:

(i) 140.53 - үйл ажиллагааны журмын талаар;

(ii) 140.55 - нисэхийн аюулгүйн хамгаалалтын баримт бичгийн хяналт болон түгээлтийн талаар;

(iii) 140.57 - бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах болон хөтлөх талаар;

(iv) 140.59 – хүсэлт гаргагчийн байгууллагын дотоод чанар баталгаажуулалтын талаар.

(10) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон

1/ байгууллагын тодорхойлолт болон энэ дүрэмд заасан үйл ажиллагааг гүйцэтгэх арга хэрэгслийн талаар;

2/ байгууллагын ажиллагсдаар тогтмол гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар;

3/ ИНД-140.51-ийн (а) 1/, 2/-т заасан орон тоон дээр ажиллах хүмүүсийн албан тушаал, нэрс болон тэдгээрийн үүрэг, хариуцлагын талаар;

4/ ажилтнуудын болон удирдах албан тушаалтнуудын үүргийг харуулсан бүдүүвч зураг;

5/ нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх байрлал бүрийн талаар болон байрлал бүр дээр байх тоног төхөөрөмж, хэрэгслийн талаарх тодорхойлолт;

6/ байрлал бүр дээр үзүүлэх нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний нарийвчлал;

7/ эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт болон Хавсралт А 23-т заасан тухайн байранд тохирсон үнэлгээний арга барил;

8/ өргөдөл гаргагч нь дараах шаардлагын дагуу журам гаргана:

8.1 энэ дүрмийн 140.53-т заасан Үйл ажиллагааны заавар;

8.2 энэ дүрмийн 140.55-д заасан нисэхийн аюулгүй байдлын баримт бичгийн хяналт, хуваарилалт;

8.3 энэ дүрмийн 140.57-д заасан бүртгэлийн ангилал, хөтлөлт, индексжүүлэлт, хадгалалт, өөрчлөлт оруулах талаар;

8.4 энэ дүрмийн 140.59-д заасан өргөдөл гаргагч байгууллагын чанар баталгаажуулалтын дотоод тогтолцооны талаар.

9/ байгууллагын Үйл ажиллагааны зааврыг хянах, өөрчлөлт оруулах, хуваарилах талаар;

-Орчуулга,
найруулга зассан

<p>түгээх журам; (11) ИНД-12-ын дагуу аюулгүйн хамгаалалтын зөрчлийг <u>Даргад</u> мэдээлэх, шинжлэн шалгах болон тайлагнах журам; (12) аюултай барааны илрүүлэлтийг Даргад мэдээлэх журам. (b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.</p>	<p>10/ ИНД-12-ийн дагуу аюулгүй байдлын зөрчлийн талаар ИНЕГ-т мэдэгдэх, шинжлэн шалгах болон тайлагнах журам; 10/ аюултай ачаа илрүүлсэн талаар ИНЕГ-т мэдэгдэх журам (b) Өргөдөл гаргагчийн Үйл ажиллагааны заавар нь ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөгдөж, баталгаажсан байна.</p>	
<p>С Бүлэг-Үйл ажиллагааны шаардлага</p>	<p>В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА</p>	
<p>140.101. <u>Байнгын</u> хэрэгжилт НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь: (1) <u>Ерөнхий зааврын нэгээс доошгүй хүчинтэй</u>, бүрэн хувийг <u>Ерөнхий зааварт</u> заасан байрлал тус бүрд байнга хадгална; (2) <u>Ерөнхий зааварт</u> дэлгэрэнгүй заасан бүх журам болон тогтолцоог байнга дагаж мөрдөнө; (3) <u>Ерөнхий зааврын</u> холбогдох бүлгийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ байнга ашиглах боломжтой байлгана; (4) дараах шаардлага болон стандартыг байнга хангаж мөрдөнө: (i) В Бүлгийн шаардлага; (ii) 140.53-ын дагуу журамтай байхыг шаардсан Хавсралт А-ийн заалт</p>	<p>140.101 <u>Тогтмол</u> хэрэгжилт (a) НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь: 1/ байгууллагын <u>Үйл ажиллагааны зааврын</u> хувийг байршил бүрд хадгална; 2/ <u>Үйл ажиллагааны зааврыг</u> тогтмол дагаж мөрдөнө; 3/ <u>Үйл ажиллагааны зааврын</u> холбогдох хэсгийн хувийг тухайн үүргийг гүйцэтгэж буй албан тушаалтан бүрт гаргаж өгнө; 4/ дараах шаардлагыг хангана: 4.1 энэ дүрмийн В Бүлэг; 4.2 энэ дүрмийн Хавсралт А-д заасан шаардлагыг тусгасан ИНД-140.53-т заасан журам.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>140.103. <u>Ерөнхий зааварт өөрчлөлт оруулах</u> (a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй: (1) <u>Ерөнхий зааврын</u> нэмэлт өөрчлөлтийг, тухайн <u>байгууллагын тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар хийсэн болохыг бататгах</u>; (2) <u>Ерөнхий зааварт</u> оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн <u>холбогдох</u> шаардлагыг хангаж байгааг бататгах; (3) <u>Ерөнхий зааварт заасан нэмэлт өөрчлөлтийн журмыг мөрдөх</u>; (4) <u>Ерөнхий зааварт</u> нэмэлт өөрчлөлт оруулсан даруйд дараа нэмэлт өөрчлөлтийн хувийг <u>Даргад</u> цаг алдалгүй хүргүүлэх; (5) нисэхийн аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхолд шаардлагатай гэж <u>Даргын</u> үзсэн нэмэлт өөрчлөлтийг <u>Ерөнхий заавартаа</u> оруулах. (b) Гэрчилгээ эзэмшигч нь <u>дараах өөрчлөлтийг</u> хийхийг санал болгож байгаа бол, <u>Даргын зөвшөөрлийг урьдчилан</u> авах шаардлагатай: (1) <u>Гүйцэтгэх захирал</u>; (2) <u>нэр заагдсан</u> удирдах ажилтнууд; (3) нисэхийн <u>аюулгүйн хамгаалалтын</u> үйлчилгээ үзүүлэх</p>	<p>140.103 <u>Үйл ажиллагааны зааварт өөрчлөлт оруулах</u> (a) Гэрчилгээ эзэмшигч нь: 1/ <u>үйл ажиллагааны зааварт өөрчлөлт оруулахдаа байгууллагын үндсэн бүтцийг хадгална</u>; 2/ <u>үйл ажиллагааны зааварт</u> аливаа өөрчлөлт оруулахдаа энэ дүрмийн шаардлагад нийцүүлнэ; 3/ <u>үйл ажиллагааны зааварт</u> өөрчлөлт оруулсан тухай бүрд түүний хувийг ИНЕГ-т хүргүүлнэ; 4/ ИНЕГ-аас зайлшгүй шаардлагатай гэж үзсэн нэмэлт, өөрчлөлтийг <u>үйл ажиллагааны заавартаа</u> оруулна. (b) Гэрчилгээ эзэмшигч нь <u>дараах өөрчлөлтийг</u> хийхдээ ИНЕГ-ын <u>саналыг</u> авна: 1/ <u>удирдах албан тушаалтныг</u> солих; 2/ удирдах ажилтныг солих; 3/ нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх байрлалыг</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p> <p>-“ИНЕГ” гэснийг “Дарга” гэж өөрчлөгдсөн</p>

<p>байрлал; (4) гэрчилгээнд заасан үйл ажиллагааны цар хүрээ; (5) байгууллагын дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо.</p> <p>(с) Энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлтийг хийх хүсэлтийг САА 24140/01 маягтын дагуу гаргана. (d) Энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа дагаж мөрдөх нөхцөлийг <u>Дарга</u> тогтоож болно. (e) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (d)-гийн дагуу тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй. (f) Энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлт нь гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бол гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг <u>Даргад</u> цаг алдалгүй хүргүүлнэ.</p>	<p>өөрчлөх; 4/ <u>гэрчилгээний үйлчлэх хүрээг өөрчлөх</u>; 5/ байгууллагын чанар баталгаажуулалтын дотоод тогтолцоонд өөрчлөлт оруулах; 6/ <u>аюулгүй байдлын үйлчилгээний төрлийг өөрчлөх</u>.</p> <p>(в) Энэ зүйлийн (б)-д заасан өөрчлөлтийг хийхдээ ИНЕГ-140/01 маягтын дагуу өргөдөл гаргана. (г) <u>ИНЕГ</u>-аас ИНД-140.103-ын (б)-д заасан өөрчлөлтийг дагаж мөрдөх нөхцөлийг тодорхойлно. (д) НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь ИНД-140.103-ын (г)-д заасан нөхцөлүүдийг мөрдөнө. (е) НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь ИНД-140.103-ын (б)-д заасан зүйлүүдэд өөрчлөлт хийх шаардлагатай болсноо <u>ИНЕГ</u>-т мэдэгдэнэ.</p>	
<p>Хавсралт А-Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны стандарт</p>	<p>Г БҮЛЭГ. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАВСРАЛТ А. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТ</p>	
<p>А.1. Үзлэгийн дараах бүсийг шалгах НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана: (1) НАХ-ын ажилтан нь үзлэгийн дараах бүсийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулах зорилгоор, дараах нөхцөлд шалгалт хийдэг байх: (i) зорчигчийн аюулгүйн үзлэг эхлэхийн өмнө; (ii) тухайн бүсийн хяналт алдагдсан байж болзошгүй үед.</p> <p>(2) НАХ-ын ажилтан нь үзлэгийн дараах бүсэд шалгалт хийхдээ: (i) үзлэгийн дараах бүсэд ямар нэгэн зөвшөөрөгдөөгүй эд зүйл орхиогүй, эсхүл нуугаагүйг шалгадаг байх; (ii) аюулгүйн үзлэгт хамрагдсан бүх этгээдийг, аюулгүйн үзлэгт хамрагдаагүй этгээдээс тусгаарласныг шалгадаг байх.</p> <p>(3) дараах үечлэлээр сорилт, эсхүл шалгалт хийдэг байх: (i) үзлэгийн дараах бүсийн шалгалтын нягт нямбай байдлыг, 28 хоног тутамд; (ii) А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу, үзлэгийн дараах бүсийн шалгалтыг гүйцэтгэдэг НАХ-ын ажилтнуудын ур чадварыг, 150 хоног тутамд.</p>	<p>А 1. Үзлэгийн дараах бүсийг шалгах НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь 1/ Аюулгүй байдлын ажилтан дараах нөхцөлд үзлэгийн дараах бүсийг: (i) зорчигчийн үзлэг эхлэхээс өмнө урьдчилан; (ii) тухайн бүсийн аюулгүй байдлыг баталгаажуулахын тулд үзлэгийн дараа хяналтын хуудас ашиглаж тус тус шалгаж байгаад хяналт тавина. 2/ Үзлэгийн дараах бүсэд шалгалт хийхдээ : (i) үзлэгийн дараах бүсэд ямар нэгэн хориглосон эд зүйлс орхисон буюу нуусан эсэх ; (ii) үзлэгт хамрагдсан зорчигч үзлэгт хамрагдаагүй хүмүүсээс тусгаарлагдсан эсэхэд хяналт тавина. 3/ Дараах шалгалтуудыг авна: (i) үзлэгийн дараах бүсэд аюулгүй байдлын үзлэг гүйцэтгэх ажилтнаас 28 хоног тутамд; (ii) энэ Хавсралтын 24-т заасан шалгалтыг 150 хоног тутамд.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>А.2. Үзлэгийн дараах бүсийн аюулгүйн хамгаалалтын хяналт НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана: (1) тухайн агаарын хөлөгт зөвшөөрөгдөөгүй эд зүйл нэвтрээгүй болохыг бататгах зорилгоор, зорчигчоос бусад этгээд</p>	<p>А 2. Үзлэгийн дараах бүсийн аюулгүй байдлын хяналт Аюулгүй байдлын ажилтан нь: 1/ үзлэгийн дараах бүсэд худалдах бараа таваар, тэнд ажилладаг хүмүүст үзлэг хийнэ;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>үзлэгийн дараах бүсэд авч орох, эсхүл хүргэх бүх бараа болон хангамжийн зүйлд аюулгүйн үзлэг, эсхүл аюулгүйн хамгаалалтын хяналт хийдэг байх;</p> <p>(2) түүний НАХ-ын ажилтан нь үзлэгийн дараах бүсийн бүрэн бүтэн байдлыг бататгах зорилгоор үзлэгийн дараах бүс доторх хөдөлгөөнд хяналт тавьдаг байх.</p>	<p>2/ үзлэгийн дараах бүсийн хөдөлгөөнд хяналт тавина.</p>	
<p>А.3. Агаарын хөлгийн шалгалт</p> <p>(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, түүний НАХ-ын ажилтан агаарын хөлгийн шалгалтыг хийхдээ дараах шаардлагыг хангасан болохыг бататгана:</p> <p>(1) зорчигчийн суудал, суудлын дээрх тээшний тасалгаа, шалны талбай, бие засах газар болон <u>өмнөх</u> үйлчилгээний зорчигчийн нэвтэрсэн байж болох бусад хэсгийг хамруулдаг байх;</p> <p>(2) бүхээгт нуусан, эсхүл бусад хэлбэрээр нэвтрүүлсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг илрүүлэхийн тулд хангалттай хүчин чармайлт гаргадаг байх.</p> <p>(б) Тухайн нислэг өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бол, гэрчилгээ эзэмшигч дараах шаардлага хангасан болохыг бататгана:</p> <p>(1) НАХ-ын ажилтан нь үйл ажиллагаа эрхлэгчийн тусламжтайгаар тухайн агаарын хөлгийг бүрэн гүйцэд шалгасан байх;</p> <p>(2) тухайн шалгалтыг, үйл ажиллагаа эрхлэгчийн агаарын хөлөгт зориулсан шалгах хуудсыг ашиглан, төлөвлөсөн хэлбэрээр гүйцэтгэсэн байх;</p> <p>(3) тухайн шалгалтаар, агаарын хөлөгт нуусан, эсхүл бусад хэлбэрээр нэвтрүүлсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг илрүүлэх хангалттай хүчин чармайлт гаргадаг байх.</p> <p>(с) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:</p> <p>(1) энэ зүйлийн (а), эсхүл (б)-гийн дагуу хийсэн шалгалтын хувьд, дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан бүртгэл хөтөлдөг байх:</p> <p>(i) тухайн шалгалтыг хийсэн ажилтны нэр;</p> <p>(ii) илрүүлсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйл;</p> <p>(iii) аюулгүй болгох арга хэмжээ авсан эсэх.</p> <p>(2) дараах шаардлагыг бататгах сорилт, эсхүл шалгалт хийдэг байх:</p> <p>(i) шалгасан байхыг шаардсан агаарын хөлгийн шалгалтын нягт нямбай байдлыг, 28 хоног тутамд;</p> <p>(ii) А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу, аюулгүйн үзлэг хийгдээгүй, эсхүл агаарын хөлгийн өндөр эрсдэлтэй шалгалт гүйцэтгэдэг НАХ-ын ажилтнуудын ур чадварыг 150 хоног тутамд.</p>	<p>А 3. Агаарын хөлгийн шалгалт</p> <p>(а) НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн аюулгүй байдлын ажилтан нь агаарын хөлөгт шаардлагатай үед дараах үзлэгийг хийнэ:</p> <p>1/ зорчигчийн суудал, гар тээшний тавиур, шал, бие засах газар болон зорчигчийн нэвтэрч болох бусад хэсэгт;</p> <p>2/ шалгалт хийхдээ агаарын хөлөгт авч орсон буюу нуусан хориглосон эд зүйлийг илрүүлэх хангалттай хэрэгсэлтэй байна.</p> <p>(б) Өндөр эрсдлийн нислэгийн үед НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь:</p> <p>1/ агаарын хөлгийн шалгалтыг аюулгүй байдлын ажилтан, агаарын тээвэрлэгчийн тусламжтайгаар бүрэн төгс хийнэ;</p> <p>2/ шалгалтыг тухайн агаарын тээвэрлэгчийн хяналтын хуудсын дагуу гүйцэтгэнэ;</p> <p>3/ агаарын хөлөгт авч орсон буюу нуусан хориглосон эд зүйлийг илрүүлэх хангалттай хэрэгсэлтэй байна.</p> <p>(в) Гэрчилгээ эзэмшигч нь</p> <p>1/ Шалгалтын дараа, дараах зүйлийг багтаасан тайланг гаргана:</p> <p>(i) шалгалт хийсэн аюулгүй байдлын ажилтны нэрс;</p> <p>(ii) хурааж авсан эд зүйлс;</p> <p>(iii) авсан арга хэмжээ;</p> <p>2/ дараах шалгалтуудыг авна:</p> <p>(i) агаарын хөлгийн аюулгүй байдлын шалгалт гүйцэтгэх ажилтнаас 28 хоног тутамд;</p> <p>(ii) энэ Хавсралтын А24-т заасан шалгалтыг 150 хоног тутамд.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>А.4. Аюулгүйн үзлэгийн цэгийн <u>хамгаалалт</u> болон</p>	<p>А 4. Аюулгүй байдлын үзлэгийн цэг, <u>тоног</u> төхөөрөмж</p>	

<p>төхөөрөмж НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:</p> <p>(1) тухайн аюулгүйн үзлэгийн цэг нь, аюулгүйн хамгаалалтын хяналтгүй бүсээс үзлэгийн дараах бүсэд нэвтрэх бүх этгээд тухайн цэгээр заавал дамжин өнгөрдөг байхаар байрласан байх;</p> <p>(2) аюулгүйн үзлэгийг тухайн агаарын хөлгийн явах нислэгийг шаардлагагүй саатуулахгүй байхаар, үзлэгийн стандартыг хангасан хурдтайгаар гүйцэтгэх хангалттай тооны ажилтан болон төхөөрөмжтэй байх;</p> <p>(3) агаарын хөлөгт тээвэрлэх боломжтой, овор ихтэй эд зүйлийг бүртгэгдсэн тээш хэлбэрээр тээвэрлүүлэхээр холбогдох агаарын тээвэрлэгчид хүлээлгэн өгдөг байх;</p> <p>(4) НАХ-ын ажилтан нь стандарт сорилын биет ашиглан тухайн аюулгүйн үзлэгийн төхөөрөмжийг чадварлагаар шалгаж чадахыг бататгах зааварчилгаа авдаг байх;</p> <p>(5) аюулгүйн үзлэгийн цэгт ашиглаж байгаа металл илрүүлэгчид:</p> <p>(i) зорчигчийн аюулгүйн үзлэг эхлэхээс өмнө Даргын хүлээн зөвшөөрөхүйц стандарт сорилын биетээр сорилт хийдэг байх;</p> <p>(ii) зөвхөн тухайн стандарт сорилын биетийг мэдрэн зөв ажилласан нөхцөлд ашигладаг байх.</p> <p>(6) аюулгүйн үзлэгийн цэгт ашиглаж байгаа рентген аппаратад Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр сорилт хийдэг байх.</p>	<p>НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь:</p> <p>1/ аюулгүй байдлын үзлэгийн дараах бүсэд орох хүн бүр үзлэгийн цэгээр дамжиж орохоор үзлэгийн цэгийг зохион байгуулна;</p> <p>2/ онц шаардлагагүйгээр агаарын хөлгийн нислэгийг саатуулахгүй аюулгүй байдлын үзлэг хийхэд хангалттай хүн хүч, тоног төхөөрөмжтэй байна (Хавсралт 2);</p> <p>3/ аюулгүй байдлын ажилтанд үзлэгийн тоног төхөөрөмжийг шалгах стандартын тестийг ашиглах зааварчилгааг өгсөн байна;</p> <p>4/ үзлэгийн цэгт ашиглаж байгаа металл илрүүлэгч багаж бүрийг:</p> <p>(i) зорчигчийн үзлэг эхлэхээс өмнө ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн стандартын тестийн дагуу шалгана;</p> <p>(ii) стандартын тестэд эерэг хариу өгч байгаа тохиолдолд багажийг үзлэгт ашиглана.</p> <p>5/ аюулгүй байдлын үзлэгийн цэгт ашиглаж буй бүх рентген туяаны аппаратыг ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн тестийн дагуу шалгана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>А.5. Хүнд аюулгүйн үзлэг хийх</p> <p>(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүйн үзлэгийн цэг бүрд, бүх этгээд аюулгүйн үзлэгээр орохыг анхааруулсан дараах мэдэгдлийг байрлуулна:</p> <p>(1) аюулгүйн үзлэгийг зөвхөн тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгээр түүнд, эсхүл түүний тээшинд хийдэг байх;</p> <p>(2) аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан этгээдийг тухайн цэгээс цааш нэвтрүүлдэггүй байх;</p> <p>(3) аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан зорчигчийг агаарын тээвэрлэгч тээвэрлэхээс татгалздаг байх.</p> <p>(b) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:</p> <p>(1) НАХ-ын ажилтан нь аливаа этгээдэд аюулгүйн үзлэг хийснээс бусад тохиолдолд, тухайн этгээдийг аюулгүйн үзлэгийн цэгээр дамжин үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй байх;</p>	<p>А 5. Аюулгүй байдлын үзлэг хийх</p> <p>(a) НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүй байдлын үзлэгийн цэг бүрт тухайн бүсээр нэвтрэх хүн бүр үзлэгээр орохыг анхааруулсан тэмдэг (Хавсралт 3) байршуулсан байна:</p> <p>1/ тухайн зорчигчийн зөвшөөрсний дагуу зорчигчийн бие, түүний тээшинд үзлэг хийж, бүртгэл хөтлөнө (Хавсралт 4);</p> <p>2/ үзлэг хийлгэхээс татгалзсан зорчигчийг үзлэгийн цэгт орохыг хориглоно;</p> <p>3/ зорчигч аюулгүй байдлын үзлэг хийлгэхээс татгалзвал агаарын тээвэрлэгч тээвэрлэхийг хориглоно.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигч нь:</p> <p>1/ аюулгүй байдлын ажилтан үзлэгт ороогүй хүнийг аюулгүй байдлын үзлэгийн цэгээр дамжуулан үзлэгийн дараах бүсэд оруулж байгаа эсэхэд хяналт тавих;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(2) тухайн этгээдийг Засгийн газраас тусгайлан чөлөөлснөөс бусад тохиолдолд, НАХ-ын ажилтан тухайн зорчигч, эсхүл багийн гишүүнд аюулгүйн үзлэг хийхгүйгээр үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй байх;</p> <p>(3) НАХ-ын ажилтан аливаа этгээдэд аюулгүйн үзлэг хийхдээ, тухайн этгээд зөвшөөрөгдөөгүй эд зүйл тээвэрлээгүй, эсхүл биедээ авч яваагүй болохыг бататгадаг байх;</p> <p>(4) дараах шаардлагыг бататгах сорилт, эсхүл шалгалт хийдэг байх:</p> <p>(i) аюулгүйн үзлэгийн нягт нямбай байдлыг, 28 хоног тутамд;</p> <p>(ii) А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу, аюулгүйн үзлэг гүйцэтгэдэг НАХ-ын ажилтнуудын ур чадварыг, 150 хоног тутамд.</p>	<p>2/ Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрөөр /Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар/ аюулгүй байдлын үзлэгээс чөлөөлөгдөөгүй бүх хүн үзлэгийн дараах бүс рүү нэвтрэх бүрдээ үзлэгт хамрагдаж, биедээ авч яваа эд зүйлийг шалгуулж байгаа эсэхэд;</p> <p>3/ аюулгүй байдлын ажилтан нь зорчигч ямар нэгэн хориглосон эд зүйлс авч орох гэж байгаа эсэхэд тус тус хяналт тавина;</p> <p>4/ зорчигчийг байхгүй үед сэжигтэй тээшийг задлахдаа хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулан хийж, акт үйлдэж баталгаажуулна (Хавсралт 8);</p> <p>5/ аюулгүй байдлын ажилтнаас дараах шалгалтуудыг авна: (i) аюулгүй байдлын үзлэгийн шалгалтыг 28 хоног тутамд; (ii) энэ Хавсралтын А 24-т заасан шалгалтыг 150 хоног тутамд.</p>	
<p>А.6. Рентген төхөөрөмжөөр аюулгүйн үзлэг хийх</p> <p>(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь түүний НАХ-ын ажилтан эд зүйлд рентген төхөөрөмж ашиглан аюулгүйн үзлэг хийхдээ дараах шаардлагыг хангасан болохыг бататгана:</p> <p>(1) тухайн зүйлд зөвшөөрөгдөөгүй эд зүйл агуулагдаагүй гэдэгт итгэлтэй байх;</p> <p>(2) рентген төхөөрөмжийн дэлгэцэн дээр гарсан дүрсийг 10 минутаас дээш хугацаагаар тасралтгүй ажиглахгүй байх.</p> <p>(б) Тухайн эд зүйл өөр эд зүйлд агуулагдсаны улмаас рентген төхөөрөмжийн шалгалтаар зөвшөөрөгдөөгүй эд зүйл биш болох нь үнэн зөв танигдахгүй байгаа, эсхүл ямар нэг эргэлзээ байгаа бол НАХ-ын ажилтан нь эд зүйлийг зөв таних хүртэл тухайн эд зүйл эсхүл түүнийг авч яваа этгээдийг үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй болохыг гэрчилгээ эзэмшигч бататгана.</p> <p>(с) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах сорилт, эсхүл шалгалт хийнэ:</p> <p>(1) рентген төхөөрөмжийн аюулгүйн үзлэгийн зөв ажиллагааг 28 хоног тутамд;</p> <p>(2) А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу, рентген төхөөрөмжөөр аюулгүйн үзлэг гүйцэтгэдэг НАХ-ын ажилтны ур чадварыг, 150 хоног тутамд.</p>	<p>А 6. Рентген туяаны аппаратаар үзлэг хийх</p> <p>(а) Рентген туяаны аппаратаар үзлэг хийх аюулгүй байдлын ажилтан нь :</p> <p>1/ ямар нэгэн хориглосон эд зүйлс авч яваа эсэхийг шалгана;</p> <p>2/ дэлгэцэн дээрх дүрсийг 10 минутаас хэтрэхгүй хугацаанд харна.</p> <p>(б) Рентген туяаны аппаратаар үзлэг хийх үед хориглосон зүйл илрэх, эсхүл ямар нэгэн сэжиг бий болсон тохиолдолд аюулгүй байдлын ажилтан нь дахин шалгах ба зөвхөн эерэг хариу гарсан нөхцөлд тухайн хүн болон авч яваа эд зүйлийг үзлэгийн дараах бүс рүү нэвтрүүлнэ.</p> <p>(в) Гэрчилгээ эзэмшигч нь дараахь шалгалт буюу тест авна:</p> <p>(i) рентген туяаны аппаратаар аюулгүй байдлын үзлэг гүйцэтгэх ажилтнаас 28 хоног тутамд;</p> <p>(ii) энэ Хавсралтын А24-т заасан шалгалтыг 150 хоног тутамд.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>А.7. Гар тээшийг гараар шалгах</p> <p>(а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:</p> <p>(1) НАХ-ын ажилтан нь гар тээшинд гараар үзлэг хийхдээ, ямар нэг зөвшөөрөгдөөгүй эд зүйл агуулагдаагүй гэдэгт</p>	<p>А 7. Гар тээшийг гараар шалгах</p> <p>(а) Аюулгүй байдлын ажилтан нь:</p> <p>1/ гар тээшинд зорчигч ямар нэгэн хориглосон зүйл авч яваа эсэхийг шалгана;</p>	

<p>итгэлтэй байх;</p> <p>(2) НАХ-ын ажилтан нь гар тээшинд ямар нэг зөвшөөрөгдөөгүй эд зүйл агуулагдаагүй гэдэгт итгэлтэй болсноос бусад тохиолдолд, тухайн тээшийг агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглодог ба агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгддэг байх;</p> <p>(3) хэрэв тухайн эд зүйл тэсрэх бодис агуулсныг сэжиглэх шалтгаан байгаа бол НАХ-ын ажилтан нь А.11(б)(5)-д шаардсан журмыг мөрддөг байх.</p> <p>(b) Тухайн зорчигч компьютер, видео камер, эсхүл ижил төстэй эд зүйлээ рентген төхөөрөмжөөр шалгуулахаас татгалзсан тохиолдолд, НАХ-ын ажилтан нь дараах ажиллагааг гүйцэтгэх хүртэл тухайн эд зүйл болон түүнийг авч яваа этгээдийг үзлэгийн дараах бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй болохыг Гэрчилгээ эзэмшигч бататгана:</p> <p>(1)хэрэв боломжтой бол, тухайн эд зүйлийг гараар шалгах ба зорчигчоос тухайн төхөөрөмжийг ажиллуулахыг шаардана;</p> <p>(2)хэрэв гараар шалгах боломжгүй бол, тухайн эд зүйл дараах шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд, бүхээгт авч орохыг зөвшөөрч болно:</p> <p>(i) тухайн эд зүйл хэвийн ажиллаж байгаа бол;</p> <p>(ii) тухайн эд зүйлийн харагдах байдал нь шинэ, эсхүл шинэвтэр бол;</p> <p>(iii) тухайн хайрцаг савны эрэг боолт гэмтсэн, эсхүл өөрчлөгдсөн шинж тэмдэггүй бол;</p> <p>(iv) тухайн зорчигчийн төлөв байдалд эргэлзээ төрүүлэх шалтгаан ажиглагдаагүй бол;</p> <p>(v)тухайн эд зүйл, эсхүл түүний агууламжийн хувьд, эргэлзээ төрүүлэх бусад шалтгаан байхгүй бол.</p> <p>(c) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах сорилт, эсхүл шалгалт хийнэ:</p> <p>(1)гар шалгалтын нягт нямбай байдлыг, 28 хоног тутамд;</p> <p>(2)А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу, гар шалгалт гүйцэтгэдэг НАХ-ын ажилтнуудын ур чадварыг, 150 хоног тутамд</p>	<p>2/ сэжиг бүхий гар тээшинд үзлэг хийсний дараа агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон ямар нэгэн зүйл илэрсэн бол түүнийг тухайн агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглох ба энэ талаар тээвэрлэгчид мэдэгдэнэ.</p> <p>3/ гар тээшинд ямар нэгэн тэсэрч дэлбэрэх бодис байна гэсэн сэжиг бий болсон тохиолдолд аюулгүй байдлын ажилтан энэ Хавсралтын А 11-ийн (б)-гийн (5)-д заасан журмын дагуу ажиллана.</p> <p>(б) Компьютер, видео камер болон бусад адилтгах хэрэгсэлтэй зорчигч нь рентген туяаны аппаратаар үзлэг хийлгэхээс татгалзсан тохиолдолд аюулгүй байдлын ажилтан :</p> <p>1/ гараар үзлэг хийх ба зорчигчоос дээрх хэрэгслийг ажиллуулж үзүүлэхийг шаардана;</p> <p>2/ гараар үзлэг хийх боломжгүй тохиолдолд тухайн хэрэгслийг агаарын хөлөгт авч орохоос өмнө:</p> <p>(i) хэрэгсэл нь ажиллаж байгаа эсэх;</p> <p>(ii) хэрэгсэл нь шинэ бол сав, баглааг нээж үзэх;</p> <p>(ii) тухайн хэрэгсэл болон түүнийг агуулж байгаа савыг засч сольсон шинж тэмдэг байгаа эсэхийг шалгах;</p> <p>(iv) зорчигч нь ямар нэгэн сэжигтэй хөдөлгөөн хийж байгаа эсэхийг ажиглана;</p> <p>(в) Гэрчилгээ эзэмшигч нь дараахь шалгалт буюу тест авна:</p> <p>(i) гараар хийх аюулгүй байдлын үзлэгийг 28 хоног тутамд;</p> <p>(ii) энэ Хавсралтын А24-т заасан шалгалтыг 150 хоног тутамд.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>А.9. <u>Аюулгүйн үзлэг хийж байгаа этгээдэд</u> тавих хяналт НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, түүний НАХ-ын ажилтан дараах шаардлагыг хангадаг болохыг бататгана:</p> <p>(1)рентген төхөөрөмжөөр ажил үүрэг гүйцэтгэж байхдаа:</p> <p>(i) эргэлзээ төрүүлж байгаа этгээдийн талаар анхааруулах дохио өгдөг байх;</p> <p>(ii) авч яваа эд зүйлийг дамжлага шугам дээр байрлуулахдаа</p>	<p>А 9. <u>Үзлэгт орсон зорчигчдод</u> хяналт тавих НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлд хяналт тавина:</p> <p>1/ рентген туяаны аппарат дээр эд зүйл байршуулах ажилтан нь:</p> <p>(i) сэжигтэй хүний талаар мэдээлэх;</p> <p>(ii)рентген туяаны аппаратын тавцан дээр тээшийг зөв байрлуулсан эсэх;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>рентген төхөөрөмжөөр үзлэг шалгалт хийж байгаа НАХ-ын ажилтан үүргээ гүйцэтгэхэд хялбар байхаар байрлуулсныг бататгадаг байх;</p> <p>(2) гар металл илрүүлэгчээр ажил үүрэг гүйцэтгэж байхдаа металл илрүүлэгч хаалга дохио өгсөн эсэхээс үл хамааран, эргэлзээ төрүүлж байгаа бүх этгээдэд аюулгүйн үзлэг хийдэг байх.</p>	<p>(iii) зорчигч урсгалд хяналт тавьж, зохицуулалт хийх; 2/ металл илрүүлэгч багаж дээр ажиллаж буй ажилтан нь үзлэгийн дараах бүс рүү нэвтрэх хүмүүст үзлэг хийх үүрэгтэй.</p>	
<p>A.10. Аюулгүйн үзлэгийн зөрчил</p> <p>(a) Аюулгүйн үзлэг хийгдсэн зорчигч үзлэгийн дараах бүсэд аюулгүйн үзлэг хийгдээгүй зөвшөөрөлгүй этгээдтэй харьцсан бол, түүний НАХ-ын ажилтан дараах шаардлагыг хангадаг болохыг НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч бататгана.:</p> <p>(1) үзлэгийн дараах бүсээс бүх хүмүүсийг гаргадаг байх; (2) үзлэгийн дараах бүсэд зөвшөөрөгдөөгүй эд зүйл үлдээгүй болохыг бататгах зорилгоор давтан шалгалт хийдэг байх; (3) А.5(b)-ийн дагуу үзлэгийн дараах бүсэд нэвтэрч байгаа бүх этгээдийг аюулгүйн үзлэгт давтан хамруулдаг байх.</p> <p>(b) Үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлгийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд илэрвэл, аюулгүйн үзлэг хийгдсэн болон хийгдээгүй хүмүүс холилдоогүй байсан ч, энэ нь тухайн эрсдэлтэй бүсэд шалгалт хийх хангалттай нөхцөл болно.</p>	<p>A 10. Нисэхийн аюулгүй байдлын үзлэгийн журмыг зөрчих</p> <p>(a) Үзлэгт ороогүй хүмүүс үзлэгийн дараах бүсэд нэвтэрсэн тохиолдолд аюулгүй байдлын ажилтан дараах арга хэмжээг авна:</p> <p>1/ үзлэгийн дараах бүсийг бүрэн чөлөөлнө; 2/ үзлэгийн дараах бүсийг дахин шалгана; 3/ үзлэгийн дараах бүс рүү нэвтрэх бүх хүмүүст энэ Хавсралтын А5-ын (б)-гийн дагуу үзлэг хийнэ.</p> <p>(б) Үзлэгийн дараах бүс болон агаарын хөлөгт үзлэгт ороогүй хүн байгааг илрүүлсэн тохиолдолд эрсдэл ихтэй газруудыг дахин шалгана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>A.11. Аюулгүйн үзлэгийн цэгийн онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөө болон дохио</p> <p>(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, аливаа этгээдийн аюулгүй байдал алдагдсан, эсхүл алдагдсан байж болох нөхцөл үүссэн тохиолдолд, аюулгүйн үзлэгийн цэг бүрд болон хамаарах өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн аюулгүйн үзлэгийн цэг бүрд тухайн нөхцөл байдлыг зохицуулах журмыг тогтооно.</p> <p>(b) Аюулгүйн үзлэгийн цэгүүдийн хувьд, гэрчилгээ эзэмшигч нь өөрийн журамд дараах шаардлагыг багтаасан байна:</p> <p>(1) аюулгүйн үзлэгийн цэг тус бүрд хамаарах, тухайн байгууламжийн нүүлгэн шилжүүлэх журам; (2) онцгой нөхцөл бий болсныг бусад НАХ-ын ажилтанд анхааруулах тогтолцоо; (3) НАХ-ын ажилтан аюулгүйн үзлэгийн цэг бүрд дараах нууц дохиоллыг ажиллуулах тогтолцоо:</p> <p>(i) өөрийн аюулгүйн хамгаалалтын алба болон Цагдаагийн байгууллагад мэдэгдэх; (ii) 139.57-д шаардсан Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний шаардлагын дагуу онцгой нөхцөл бий</p>	<p>A 11. Онцгой нөхцөл байдал - үзлэгийн цэгт гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, дохио</p> <p>(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүй байдлыг хангахын тулд үзлэгийн цэг дээр ажиллах журмыг тогтооно.</p> <p>(б) Энэ журамд дор дурьдсан зүйл багтана:</p> <p>1/ нүүлгэн шилжүүлэх горим; 2/ онцгой нөхцөл байдал үүссэн үед бусад аюулгүй байдлын ажилтанд мэдэгдэх харилцаа холбооны тогтолцоо; 3/ үзлэгийн цэг бүр дээр ажиллаж буй аюулгүй байдлын ажилтнаас онцгой байдлын дохиолол дуугарсан үед авах арга хэмжээ: (i) ИНЕГ болон цагдаагийн байгууллагад мэдэгдэх; (ii) Нисэх буудлын Онцгой байдлын үед ажиллах журмын дагуу бусад газруудад мэдэгдэх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

болсон талаар холбогдох бусад оролцогчдод мэдэгдэх;

(4) дараах тохиолдолд авах арга хэмжээ:

- (i) аливаа этгээд аюулгүйн үзлэгийн цэгт зөвшөөрөгдөөгүй эд зүйл авч явсан ба тухайн этгээд нь гэмт хэргийн зорилготой байж болох нөхцөл байдал илэрсэн үед;
- (ii) рентген төхөөрөмжийн дэлгэцэд зөвшөөрөгдөөгүй эд зүйл танигдсан үед, НАХ-ын ажилтан тухайн зорчигчийг сэжигтэй эд зүйлээс нь тусгаарлах оролдлого хийдэг болохыг бататгах;

(5) сэжигтэй тэсрэх хэрэгсэл илэрсэн үед авах арга хэмжээний журам:

- (i) Цагдаагийн байгууллага болон аэродромын [үйл ажиллагаа эрхлэгчид](#) мэдэгдэх;
- (ii) Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний дагуу холбогдох бусад байгууллагад мэдэгдэх;
- (iii) тухайн бүсийг чөлөөлөхөд туслах;
- (iv) тухайн зөрчил гаргагчийг илрүүлэх болон саатуулахад Цагдаагийн байгууллагад туслах.

[\(c\) Энэ зүйлийн \(a\)-д заасан журамтай өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн аюулгүйн үзлэгийн цэгүүдийн хувьд, хэрэв хамааралтай бол гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн \(b\)-д заасан эд зүйлийг тухайн журамд оруулах үүрэгтэй.](#)

A.12. Хөдөлгөөнт эргүүл

(a) Энэ зүйлийн (c), эсхүл (d)-д зааснаас бусад тохиолдолд, НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, түүний НАХ-ын ажилтан дараах зорилгоор хоногийн 24 цагийн турш хөдөлгөөнт эргүүл хийдэг болохыг бататгана:

- (1) НАХҮБ-ын гэрчилгээнд заасан байрлалын аюулгүйн хамгаалалтад заналхийлж болох этгээдийг илрүүлэх;
- (2) НАХҮБ-ын гэрчилгээнд заасан байрлалын аюулгүйн хамгаалалттай холбоотой онцгой нөхцөлд яаралтай хариу арга хэмжээ авах.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь, түүний НАХ-ын ажилтан хөдөлгөөнт эргүүл хийх үедээ дараах шаардлага хангасан болохыг бататгана:

- (1) 140.61(a)(5)-д заасан, гэрчилгээ эзэмшигчийн хариуцлагын бүс дэх байгууламжийн байрлалын талаар бүрэн мэдлэгтэй байх;
- (2) энэ зүйлийн (b)(1)-д заасан бүсийг бүрэн хамарсныг бататгадаг байх;

4/ дараах тохиолдолд авах арга хэмжээ:

- (i) үзлэгийн цэг дээр зорчигч зөвшөөрөгдөөгүй зүйл авчирсан тохиолдолд юуны түрүүнд ямар нэгэн гэмт хэргийн шинжтэй эсэхийг тогтоох;
 - (ii) рентген туяаны аппаратаар зөвшөөрөгдөөгүй зүйл илэрсэн тохиолдолд аюулгүй байдлын ажилтан тухайн зорчигчийг хураан авсан зүйлээс нь тусгаарлах;
 - (iii) нисэх буудлын хамгаалагдсан ба хориотой бүсэд зөрчил гаргасан этгээдийг тухайн бүсээс албадан гаргах;
- 5/ тэсэрч дэлбэрэх зүйл илэрсэн үед авах арга хэмжээ:

- (i) цагдаагийн байгууллага болон аэродромын ашиглалтын байгууллагад мэдэгдэх;
- (ii) Нисэх буудлын Онцгой байдлын үед ажиллах журмын дагуу бусад газруудад мэдэгдэх;
- (iii) нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд туслах;
- (iv) зөрчил гаргагчийг саатуулахад цагдаагийн байгууллагад туслах.

-Amend.4-өөр нэмэгдсэн

A 12. Тээврийн хэрэгслээр эргүүл хийх

(a) Аюулгүй байдлын хамгаалалтын ажилтан дараах зорилгоор тээврийн хэрэгслээр 24 цагийн эргүүл хийнэ:

- 1/ НАБҮБ-ын гэрчилгээнд онцлон заасан байршилд сэжигтэй этгээдийг илрүүлэх;
- 2/ НАБҮБ-ын гэрчилгээнд онцлон заасан байршилд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд яаралтай хариу арга хэмжээ авах;

(б) тээврийн хэрэгслээр эргүүл хийх аюулгүй байдлын ажилтан нь дараах үүрэгтэй:

- 1/ энэ дүрмийн 140.61-ийн (a)-гийн (5)-д заасан, гэрчилгээ эзэмшигчийн хариуцаж буй тоног төхөөрөмжийн байрлалыг мэдэж байх;
- 2/ талбайг бүрэн хамарч эргүүл хийх;

-Орчуулга, найруулга зассан

(3) эргүүлийг дараах байдлаар хийдэг байх:

- (i) тогтмол бус давтамжтай;
- (ii) зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл болон этгээдийг шалгаж тогтоох;
- (iii) аэродромын аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өөр хэлбэрээр хориглосон бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэлтийг илрүүлэх.

(4) аюулгүйн хамгаалалттай аэродромын хамгаалалттай бүсэд, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн аль нэг хэсэгт аюулгүйн хамгаалалттай холбоотой онцгой нөхцөлийн дуудлага хүлээж аваад 5 минутын дотор тухайн цэгт очдог байх;

(5) аюулгүйн хамгаалалттай бүс болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс дэх ачааны болон тээвэрлэлтийн талбайд эргүүл хийдэг байх;

(6) аэродромын аюулгүйн хамгаалалттай бүс болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс дэх навигацийн байгууламжид эргүүл хийдэг байх;

(7) аэродромын аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийг тойрсон хашаа болон хаалт, аюулгүйн хамгаалалтын периметрийн зөрчлийг илрүүлэх зорилгоор үзлэг хийдэг байх;

(8) энэ зүйлийн (b)(7)-д шаардсан үзлэг нь дараах шаардлагыг багтаасныг бататгадаг байх:

- (i) периметрийн хашааг шөнийн цагаар 3-аас доошгүй, өдрийн цагаар 3-аас доошгүй удаа эргэдэг байх;
- (ii) барилга байгууламжид өөр өөр цагт эргүүл хийдэг байх;
- (iii) аюулгүйн хамгаалалттай бүсийн болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн тэмдэг тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг шалгадаг байх;
- (iv) шаардсан хүрээг бүрэн хамарсан болохыг бататгах периметрийн үзлэгийн бүртгэл хөтөлдөг байх.

(c) НАХҮБ нь олон улсын нисэх буудлаас бусад аэродромд аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлдэг бол, НАХ-ын ажилтан нь дараах тохиолдолд энэ зүйлийн (b)(8)-ыг дагаж мөрдөхгүйгээр, хоногт 24 цагаас бага хугацаагаар тухайн аэродромд хөдөлгөөнт эргүүл хийж болно, хэрэв:

(1) аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн 24 цагийн аюулгүйн хамгаалалттай бол;

(2) НАХ-ын ажилтан нь хуваарьт нислэг гарах цагаас 90 минутын өмнө болон нислэг гарснаас хойш 15 минутын хугацаанд эргүүл хийдэг бол.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь аюулгүйн хамгаалалттай навигацийн

3/ түр эргүүл хийх, зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл, хүмүүсийг шалгах ба хориглосон талбай, аэродромын талбайд зөвшөөрөлгүй нэвтрүүлэхгүй байх;

4/ аэродромын аюулгүй байдлын талбайд онцгой нөхцөл байдал үүссэн үед 5 минутын дотор бэлэн байдалд орох;

5/ аюулгүй байдлын талбай дахь ачааны талбайд эргүүл хийх;

6/ аэродромын аюулгүй байдлын талбай дахь навигацын тоног төхөөрөмж байрлуулсан талбайд эргүүл хийх;

7/ хашаа хамгаалалт болон аэродромын аюулгүй байдлын бүсийн хамгаалалтыг шалгах, зөрчлийг илрүүлэх;

8/ энэ хэсгийн 7/-д заасан шалгалтыг хийхдээ:

- (i) шөнийн болон өдрийн цагт хашаа хамгаалалтыг 3 удаа эргэнэ;
- (ii) барилга байгууламж, тоног төхөөрөмжийг эргэнэ;
- (iii) аюулгүй байдлын талбайн тэмдгийн бүрэн бүтэн байдлыг шалгана;
- (iv) хашаа хамгаалалтыг шалгах бүрт тайлан үйлдэнэ.

(в) НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь агаарын навигацийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг 24 цагаар хамгаалж байгаа бол аюулгүй байдлын ажилтан дараах зорилгоор эргүүл хийнэ:

(1) гэрчилгээнд заасан агаарын навигацийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын үйл ажиллагаанд хохирол учруулж болзошгүй этгээдийг илрүүлэх;

(2) гэрчилгээнд заасан агаарын навигацийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдалтай холбоотой онцгой байдал үүссэн үед

-Орхигдуулсан

<p><u>байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгч бөгөөд НАХ-ын ажилтныг дараах зорилгоор эргүүл хийдэг болохыг бататгадаг бол, тухайн байгууламжид 24 цагаас бага хугацаагаар хөдөлгөөнт эргүүл хийж болно:</u></p> <p><u>(1)НАХҮБ-ын гэрчилгээнд заасан навигацгийн байгууламжийн үйл ажиллагааны аюулгүйн хамгаалалтад заналхийлж болох этгээдийг илрүүлэх;</u></p> <p><u>(2)НАХҮБ-ын гэрчилгээнд заасан навигацгийн байгууламжийн аюулгүйн хамгаалалттай холбоотой онцгой нөхцөлд яаралтай хариу арга хэмжээ авах.</u></p>	<p>яаралтай хариу арга хэмжээ авах.</p>	<p>заалтыг оруулсан</p> <p>нэмж</p>
<p>А.13. Шалган нэвтрүүлэх цэгийн аюулгүйн хамгаалалт НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, түүний НАХ-ын ажилтан дараах шаардлага хангасан болохыг бататгана:</p> <p>(1) шалган нэвтрүүлэх цэгт ажил үүрэг гүйцэтгэж байхдаа:</p> <p>(i) Хавсралт А.28-д заасны дагуу, зөвхөн хүчинтэй нэвтрэх үнэмлэх, эсхүл баримт бичигтэй этгээдийг шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрэхийг зөвшөөрдөг байх;</p> <p>(ii) шалган нэвтрүүлэх цэгийг хяналтгүй орхисон аль ч үед тухайн цэгийн аюулгүйн хамгаалалт хангагдсан болохыг бататгадаг байх;</p> <p>(2) тээврийн хэрэгслийн шалган нэвтрүүлэх цэгт үүрэг гүйцэтгэж байхдаа тухайн цэгээр зөвхөн зөвшөөрөгдсөн этгээд болон тээврийн хэрэгсэл нэвтрэхийг зөвшөөрдөг байх.</p>	<p>А 13. Шалган нэвтрүүлэх цэгийн аюулгүй байдал НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн аюулгүй байдлын ажилтан дараах үүргийг гүйцэтгэнэ:</p> <p>1/ шалган нэвтрэх цэгээр</p> <p>(i) зохих зөвшөөрөлтэй этгээд болон нисгэгчийн үнэмлэхийг шалгаж нэвтрүүлэх;</p> <p>(ii) нэвтрэх цэгийг эзэнгүй орхисон үед тухайн цэгийн аюулгүй байдлыг хангасан байх;</p> <p>2/ тээврийн хэрэгслийн шалган нэвтрүүлэх цэгээр зөвхөн эрх бүхий хүн ба тээврийн хэрэгслийг шалгаж нэвтрүүлэх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>А.14. Аюулгүйн хамгаалалтын гэнэтийн сонгох үзлэг <u>НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, түүний НАХ-ын ажилтан дараах аюулгүйн хамгаалалтын гэнэтийн сонгох үзлэг хийдэг болохыг бататгана:</u></p> <p><u>(1)аюулгүйн хамгаалалттай бүсэд, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд байгаа, эсхүл нэвтрэх гэж байгаа этгээдээс сонгож Хавсралт А-28-д заасан хүчинтэй нэвтрэх үнэмлэх, эсхүл баримт бичигтэй эсэхийг шалгах;</u></p> <p><u>(2)тээврийн хэрэгсэл нь аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд байх зөвшөөрөлтэй эсэхийг шалгах.</u></p>	<p>А 14. Хамгаалагдсан бүсийн хамгаалалт НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Хамгаалалтын үйл ажиллагааны журмыг боловсруулсан байна.</p>	<p>-Орхигдуулсан заалтыг оруулсан</p> <p>нэмж</p>
<p>А.15. Нэвтрэх үнэмлэх болон зөвшөөрлийг шалгаж бататгах НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, түүний НАХ-ын ажилтан дараах шаардлага хангадаг болохыг бататгах үүрэгтэй:</p> <p>(1)нэвтрэх зорилгоор ашигладаг нисгэгчийн үнэмлэх болон нэвтрэх үнэмлэхийг шалгаж бататгадаг байх;</p> <p>(2)хэрэв энэ зүйлийн (1)-д заасан баримт бичгийн хүчинтэй байдалд эргэлзэж байгаа бол, тухайн үнэмлэхийг</p>	<p>А 15. Нэвтрэх үнэмлэх, зөвшөөрөл шалгах НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн аюулгүй байдлын ажилтан нь:</p> <p>1/ нисгэгчийн үнэмлэх болон нэвтрэх үнэмлэхийг шалгах;</p> <p>2/ дээр дурьдсан баримт бичгийг шалгахад ямар нэгэн эргэлзээ үүссэн бол тухайн үнэмлэхийг гээсэн, үрэгдүүлсэн болон</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>гээгдүүлсэн, эсхүл хулгайлагдсан бусад байдлаар хүчингүй болсон эсэхийг шалгаж тогтоодог байх.</p>	<p>хүчингүй болгосон эсэхийг тогтоох.</p>	
<p>А.16. Аюулгүйн хамгаалалтын дагалдах үйлчилгээ</p> <p>(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аливаа этгээд, эсхүл тээврийн хэрэгслийг НАХ-ын ажилтан дагалдах шаардлагатай нөхцөл байдлыг тогтоох журамтай байна.</p> <p>(b) Гэрчилгээ эзэмшигч нь, НАХ-ын ажилтан бүр аюулгүйн хамгаалалтын дагалдах ажиллагаа гүйцэтгэж эхлэхийн өмнө дагаж байгаа этгээдэд дараах зааварчилгаа өгдөг болохыг бататгана:</p> <p>(1) хэрэв тухайн этгээд нь тээврийн хэрэгсэлтэй дагаж байгаа бол, дагуулж байгаа тээврийн хэрэгслийн араас ойрхон дагах;</p> <p>(2) дагуулж байгаа ажилтны өгч байгаа бүх зааварчилгааг мөрдөх.</p> <p>(c) Хэрэв дагаж байгаа этгээд нь аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд үлдэх бол, тухайн этгээдийг үлдээхийн өмнө ажилтан дараах зааварчилгааг өгнө:</p> <p>(1) аюулгүйн хамгаалалтын дагалдах ажилтны тогтоосон бүсийг, дагуулж байгаа ажилтангүйгээр орхихгүй байх талаар;</p> <p>(2) тухайн бүсээс гарахад аюулгүйн хамгаалалтын дагалдах ажилтан шаардлагатай бол, гэрчилгээ эзэмшигчтэй хэрхэн холбоо барих талаар.</p>	<p>А 16. Аюулгүй байдлын дагалдах үйл ажиллагаа</p> <p>(a) НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь хүмүүс болон тээврийн хэрэгслийг аюулгүй байдлын ажилтан ямар нөхцөлд дагалдах талаар журам боловсруулсан байна.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигчийн аюулгүй байдлын ажилтан нь дагалдах үйл ажиллагааг эхлэхийн өмнө тухайн хүнд дараах товч мэдээллийг өгнө:</p> <p>(1) тээврийн хэрэгслийн жолооч нь дагалдах тээврийн хэрэгслийн араас дагах;</p> <p>(2) дагаж буй аюулгүй байдлын ажилтны бүх зааварчилгааг мөрдөх.</p> <p>(в) Дагалдаж яваа хүн нь аюулгүй байдлын бүсэд үлдэхээр бол аюулгүй байдлын ажилтан дараах товч мэдээллийг өгнө:</p> <p>(1) дагалдах аюулгүй байдлын тухайн ажилтны зааж өгсөн газраас өөр тийшээ явахгүй байх;</p> <p>(2) аюулгүй байдлын бүсээс гарах бол дагалдах аюулгүй байдлын ажилтанг дуудах.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>А.17. Явган эргүүл</p> <p>НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлага хангасан болохыг бататгана:</p> <p>(1) НАХ-ын ажилтан нь иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтад заналхийлэл учруулж болох этгээдийг илрүүлэх явган эргүүл хийдэг байх;</p> <p>(2) явган эргүүл хийх НАХ-ын ажилтан нь:</p> <p>(i) хариуцсан бүс дэх байгууламжийн байрлалын талаар бүрэн мэдлэгтэй байх;</p> <p>(ii) хариуцсан бүсийг бүрэн хамарсан эргүүл хийдэг байх;</p> <p>(iii) мэдээлсэн, эсхүл тогтоосон аюулгүйн хамгаалалттай холбоотой аливаа зөрчилд нэн даруй хариу арга хэмжээ авдаг байх.</p>	<p>А 17. Явган эргүүл</p> <p>(a) НАБҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь нисэхийн аюулгүй байдалд заналхийлсэн этгээдийг илрүүлэх зорилгоор явган эргүүл хийнэ.</p> <p>(б) Явган эргүүл хийх аюулгүй байдлын ажилтан нь:</p> <p>1/ хариуцаж буй талбайдаа эргүүл хийх;</p> <p>2/ аюулгүй байдалтай холбоотой зөрчил илэрсэн үед хариу арга хэмжээг нэн даруй авах үүрэгтэй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>А.18. Агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалт</p> <p>(a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгана:</p> <p>(1) тухайн байгууллагын гэрчилгээнд заасан аэродромд</p>	<p>А 18. Агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах</p> <p>(a) Гэрчилгээнд онцлон заасан аэродромд аюулгүй байдлын ажилтан нь:</p> <p>1/ үйлчилгээнд гарсан бүх агаарын хөлгийг ерөнхий хяналтын</p>	

<p>байрлаж байгаа НАХ-ын ажилтан нь:</p> <p>(i) үйлчилгээнд байгаа бүх агаарын хөлгийг байнгын ерөнхий хяналтдаа байлгадаг байх;</p> <p>(ii) зөвшөөрөлгүй этгээд агаарын хөлөгт ойртох, эсхүл агаарын хөлгийн бүхээгт нэвтрэхээс сэргийлдэг байх;</p> <p>(iii) хүн, эсхүл зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг нуусан байж болзошгүй байрлалд анхаарал хандуулах зорилгоор олон улсын чиглэлийн үйлчилгээнд байгаа агаарын хөлгийг тойрч нүдэн үзлэг хийдэг байх;</p> <p>(2)энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд НАХ-ын ажилтан нь олон улсын чиглэлийн үйлчилгээнд байгаа бүх агаарын хөлгийн эргүүлийг дараах байдлаар хийдэг байх:</p> <p>(i) тогтмол бус давтамжтай;</p> <p>(ii) шөнийн цагаар, хоёр цаг тутамд 1-ээс доошгүй удаа;</p> <p>(iii) өдрийн цагаар, дөрвөн цаг тутамд 1-ээс доошгүй удаа;</p> <p>(3) НАХ-ын ажилтан нь дараах нөхцөлд агаарын тээвэрлэгчийн төлөөлөгчийг агаарын хөлөгт ирэхийг шаарддаг байх:</p> <p>(i) хоолойд (air-bridge) холбогдсон, хяналтгүй орхисон агаарын хөлөг нь хамгаалалтгүй бол;</p> <p>(ii) тухайн агаарын хөлөг хөндлөнгийн халдлагад өртсөн байж болох шалтгаан байгаа бол.</p> <p><u>(b) Тухайн НАХУБ нь олон улсын нисэх бүүдлаас бусад аэродромд аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлдэг бол НАХ-ын ажилтан нь дараах тохиолдолд тухайн аэродром дээр олон улсын чиглэлийн үйлчилгээнд байгаа агаарын хөлөгт энэ зүйлийн (a)(2)-т шаардсанаас бага хугацаагаар эргүүл хийж болно, хэрэв:</u></p> <p><u>(1)тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн 24 цагийн аюулгүйн хамгаалалттай бол;</u></p> <p><u>(2)НАХ-ын ажилтан нь хуваарьт нислэг гарах цагаас 90 минутын өмнө болон нислэг гарснаас хойш 15 минутын хугацаанд эргүүл хийдэг бол.</u></p>	<p>дор байлгах;</p> <p>2/ агаарын хөлөгт суух зөвшөөрөлгүй хүмүүс агаарын хөлөгт ойртох буюу нэвтрэхээс урьдчилан сэргийлэх;</p> <p>3/ хүмүүс болон хориглосон зүйлийг оруулж болох талбай, ялангуяа олон улсын нислэгт гарах гэж буй агаарын хөлгийн эргэн тойронд ил үзлэг хийх.</p> <p>(б) Олон улсын нислэгийн бүх агаарын хөлгийн орчимд эргүүл хийхдээ дараах журмаар хийнэ:</p> <p>1/ тогтмол бус үндэслэлээр;</p> <p>2/ шөнийн цагт хоёр цаг тутамд;</p> <p>3/ өдрийн цагт дөрвөн цаг тутамд.</p> <p>(в) аюулгүй байдлын ажилтан нь дараах тохиолдолд агаарын тээвэрлэгчийн төлөөлөгчид агаарын хөлгөө шалгах хүсэлт гаргана:</p> <p>(i) үйлчилгээнд гараагүй агаарын хөлөгт шат тогтоосон, эсхүл түүний аюулгүй байдал алдагдсан;</p> <p>(ii) агаарын хөлөгт нэвтэрсэн байж болох сэжигтэй зүйл илэрсэн.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Орхигдуулсан заалт нэмж оруулсан</p>
<p>А.19. Эргүүлийн тээврийн хэрэгсэл</p> <p>НАХУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд эргүүл хийхэд ашигладаг тээврийн хэрэгсэл нь дараах шаардлага хангасан болохыг бататгана:</p> <p>(1) аэродромын бусад хэрэглэгчдэд танигдахуйц таних тэмдэгтэй байх;</p> <p>(2) <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц стандартын дагуу</p>	<p>А 19. Тээврийн хэрэгслээр эргүүл хийх</p> <p>Гэрчилгээ эзэмшигч нь аюулгүй байдлын талбайд эргүүл хийхэд зориулагдсан, дараах шаардлагыг хангасан тээврийн хэрэгсэлтэй байна:</p> <p>1/ бусад аэродромын тээврийн хэрэгслээс ялгарах тэмдэг тавьсан байна;</p> <p>2/ зохих журмын дагуу тоноглогдсон.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>тоноглогдсон байх.</p> <p>А.20. <u>Нууцлал болон мэдээлэл</u> НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, ангилсан баримт бичгийг дараах шаардлага хангасан болохыг бататгана: (1)ангиллаас нь хамааран сейфэнд, эсхүл түгжээтэй шүүгээнд хадгалдаг байх; (2)зөвхөн “мэдэж байх шаардлагад” үндэслэн, тэдгээрийг хүлээн авахаар зөвшөөрөгдсөн хувь хүн, эсхүл байгууллагад түгээдэг байх.</p>	<p>А 20. <u>Баримт бичгийг нууцлах</u> Гэрчилгээ эзэмшигч нь байгууллагын нууцын тухай хуульд заасан мэдээллээс бусад өөрийн үйл ажиллагаанд ашиглаж буй баримт бичгүүдийг нууцлах ба зөвхөн эрх бүхий хүмүүсийн зөвшөөрөлтэйгээр олгоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>А.21. <u>Бусад байгууллагатай харилцах</u> (а)НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, 140.61(а) (5)-д заасан байрлал бүрийн хувьд, дараах үүрэгтэй: (1)тухайн байрлал дахь үйл ажиллагааны аюулгүйн хамгаалалтад нөлөөлөх, нөөц төлөвлөгөөнд оролцох бусад бүх байгууллагатай зөвлөлдөх болон хамтарч ажиллах; (2)тухайн байрлалд байгаа бусад байгууллагын бүх ажилтны аюулгүйн хамгаалалтын мэдлэг чадварыг дээшлүүлэх хангалттай мэдээлэл өгөгдөж байгааг бататгах аюулгүйн хамгаалалтын хороо байгуулах. <u>(b)НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, энэ зүйлийн (а)(2)-ын дагуу байгуулагдсан аюулгүйн хамгаалалтын хороог 12 сард нэгээс доошгүй удаа хуралдуулж, хурлыг удирдах болон аюулгүйн хамгаалалтын хорооны үүлзалтын тэмдэглэл хөтлөх үүрэгтэй.</u></p>	<p>А 21. <u>Бусад байгууллагатай хамтарч ажиллах</u> Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд нь энэ дүрмийн 140.61-ийн (а)-гийн (5)-д заасан байршил бүрийн хувьд: 1/ тухайн байршлын аюулгүй байдлыг хангахын тулд холбогдох байгууллагатай зөвшилцөх, хамтарч ажиллана; 2/ тухайн байршлын аюулгүй байдлыг хангах бүх талын хангалттай мэдээллийг бусад байгууллагад өгнө.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-заалт нэмэгдсэн</p>
<p>А.22. <u>НАХ-ын ажилтны эрүүл мэндийн шаардлага</u> НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, эмнэлгийн үзлэгийн дүгнэлтэд үндэслэн тухайн этгээд ажил үүрэг гүйцэтгэхэд тохирч байгаа гэсэн үнэлгээг хийх хүртэл аливаа этгээдийг НАХ-ын ажилтны албан тушаалд томилдоггүй болохыг бататгана.</p>	<p>А 22. <u>Нисэхийн аюулгүй байдлын ажилтны эрүүл мэндэд тавигдах шаардлага</u> Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхлэх байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүй байдлын ажилтныг сонгохдоо тухайн ажилтны эрүүл мэндийн байдлыг харгалзана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>А.23. <u>Сургалт</u> (а) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, түүний НАХ-ын ажилтан дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, тухайн ажил үүрэг гүйцэтгэдэггүй болохыг бататгах үүрэгтэй: (1)тэдний гүйцэтгэх үүрэгт хамаарах, энэ зүйлийн (с)-д заасан сэдвээр сургалтад хамрагдсан байх; (2)сургалтын төгсгөлд бичгийн шалгалт өгсөн байх; (3)хамрагдсан сургалтын сэдэв тус бүрээр, энэ зүйлийн (с)-д заасан ур чадварын түвшнийг хангасан байх. (б) Энэ зүйлийн (с)-д заасан ур чадварын түвшний үнэлгээний тогтолцоо нь дараах хэлбэртэй байна: (1)Үнэлгээ - 1, тухайн сэдвийн ойлголтыг харуулна; (2)Үнэлгээ - 2, тухайн сэдвийн суурь мэдлэгийг харуулна; (3)Үнэлгээ - 3, тэдний ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж</p>	<p>А 23. <u>Сургалт</u> (а) Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн аюулгүй байдлын ажилтанд дараах шаардлагыг тавина: 1/ энэ хэсгийн (в)-д заасан сургалтад хамрагдсан байх; 2/ сургалтын төгсгөлд бичгээр шалгалт өгсөн байх; 3/ энэ хэсгийн (в)-д заасан түвшинд хүрсэн байх. (б) Энэ хэсгийн (в)-д заасан мэдлэгийн түвшинг дараах үнэлгээгээр дүгнэнэ: 1/ үнэлгээ 1 - сэдэвтэй танилцсан; 2/ үнэлгээ 2 - сэдвийн талаар үндсэн мэдлэгтэй болсон; 3/ үнэлгээ 3 - олж авсан үндсэн мэдлэгээ үйл ажиллагаандаа</p>	

<p>болзошгүй нөхцөл байдалд тухайн сэдвийн суурь мэдлэгээ ашиглах чадварыг харуулна;</p> <p>(4) Үнэлгээ - 4, тэдний ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөл байдалд тухайн сэдвийн бүрэн мэдлэгээ ашиглаж шийдвэр гаргах чадварыг харуулна;</p> <p>(5) Үнэлгээ - 5, тэдний ажил үүргээ гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй нөхцөл байдалд тухайн сэдвийн бүрэн мэдлэгээ ашиглан нөхцөл байдлыг зөв тодорхойлж илэрхийлэх чадварыг харуулна.</p> <p>(с) Энэ зүйлийн (а)-д заасан ажилтан нь дараах сэдвээр ур чадварын түвшин тогтоох сургалтад хамрагдаж, үнэлгээ хийлгэсэн байна:</p> <p>(1) Нисэхийн аюулгүйн хамгаалалттай холбогдолтой хууль тогтоомж:</p> <p>(i) Үнэлгээ - 4, Эрүүгийн хуульд заасан, нийтийн аюулгүйн хамгаалалт, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн талаар;</p> <p>(ii) Үнэлгээ - 3, Хүний эрхийн холбогдолтой хууль тогтоомж болон хувь хүнд нэгжлэг хийх, эсхүл баривчлан саатуулах талаар (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл);</p> <p>(iii) Үнэлгээ - 5, Иргэний нисэхийн тухай хуульд заасан НАХ-ын ажилтны эрх, үүрэг болон хариуцлагын талаар;</p> <p>(iv) Үнэлгээ - 3, Хавсралт А-гийн А.26, А.27, А.28 болон ИНД-108, 58-ын талаар;</p> <p>(v) Үнэлгээ - 3, ИНД-13 болон Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын талаар;</p> <p><u>(vi) Үнэлгээ - 3, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн талаар (Эрүүгийн хуулийн холбогдох зүйл);</u></p> <p><u>(vii) Үнэлгээ - 5, Хүч хэрэглэх болон баривчлах талаар (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалт);</u></p> <p>(2) Зорчигч, тээшинд аюулгүйн үзлэг болон шалгалт хийх:</p> <p>(i) Үнэлгээ - 4, зорчигч, тээшинд аюулгүйн үзлэг болон шалгалт хийх зохицуулалтын ерөнхий зарчмыг дүрслэх;</p> <p>(ii) Үнэлгээ - 4, гэрчилгээ эзэмшигчийн ашигладаг аюулгүйн үзлэгийн төхөөрөмжийн мэдлэгтэй ба ашиглахад мэргэшсэн байх;</p> <p>(iii) Үнэлгээ - 4, зорчигч, түүний тээшинд аюулгүйн үзлэг болон шалгалт хийх журам болон аргыг хэрэглэх дадлага туршлагатай байх;</p> <p>(3) Агаарын хөлгийн хорлон сүйтгэх ажиллагааны эсрэг шалгалт: Үнэлгээ - 4, заналхийллийн дараа, агаарын хөлөгт хорлон</p>	<p>ашиглах чадвартай;</p> <p>4/ үнэлгээ 4 - тухайн сэдвийн талаарх мэдлэгийг өөрийн үйл ажиллагаандаа ашиглах чадвартай;</p> <p>5/ үнэлгээ 5 - тухайн сэдвийн талаарх мэдлэгийг өөрийн үйл ажиллагаанд ашиглахаас гадна дасгал сургуулилт хийх чадвартай.</p> <p>(в) Аюулгүй байдлын ажилтан нь дараах сэдвийг багтаасан сургалтад хамрагдсан байна:</p> <p>1/ Нисэхийн аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомж :</p> <p>(i) Иргэний нисэхийн хууль</p> <p>(ii) Эрүүгийн хууль</p> <p>(iii) Захиргааны хариуцлагын тухай хууль</p> <p>(iv) Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр</p> <p>(v) Иргэний нисэхийн багц дүрмүүд</p> <p>2/ Зорчигч, тэдгээрийн тээшинд үзлэг хийх, шалгах</p> <p>(i) зорчигч, тэдгээрийн тээшинд үзлэг хийх, шалгахад баримтлах ерөнхий зарчим- үнэлгээ 4;</p> <p>(ii) гэрчилгээ эзэмшигчийн үзлэгийн тоног төхөөрөмжийн талаар сайн мэдлэгтэй байх ба чадварлаг ашигладаг байх үнэлгээ 4;</p> <p>(iii) зорчигч, тэдгээрийн тээшинд үзлэг хийх горим, журмын талаар туршлагатай байх үнэлгээ 4;</p> <p>3/ Агаарын хөлгийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах үзлэг, шалгалт /Нислэгийн өмнөх шалгалт-үнэлгээ 4/;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Орхигдуулсан заалт нэмж оруулсан</p>
--	---	---

сүйтгэх ажиллагааны эсрэг шалгалт хийх шаардлагатай үед хариу үйлдлийг шалгах, эсхүл хэрэв тухайн агаарын хөлөг өмнө нь аюулгүйн үзлэг хийлгэлгүй үйлчилгээнд оролцсон бол, түүнийг дараагийн нислэгийн өмнөх аюулгүйн үзлэгийн өмнө, аюулгүй болохыг бататгахаар авах арга хэмжээний талаар;

- (4) Гар хийцийн тэсрэх төхөөрөмж: Үнэлгээ - 3, НАХ-ын ажилтанд нисэх буудал, агаарын хөлөг, эсхүл зорчигчийн аюулгүйн үзлэгийн цэгт илэрч болох, иргэний нисэхийн аюулгүй байдалд нөлөөлдөг гар хийцийн тэсрэх төхөөрөмжийн талаар ойлголт өгөх;
- (5) Зэвсэглэсэн гэмт хэрэгтэнтэй харьцах: Үнэлгээ - 3, НАХ-ын ажилтанд зэвсэглэсэн гэмт хэрэгтнийг саатуулах болон бусад этгээдийг тухайн заналхийллээс хамгаалах арга хэмжээний талаар зааварчилгаа өгөх;
- (6) Агаарын хөлөг барьцаалахын эсрэг хариу үйлдлийн журам: Үнэлгээ - 2, НАХ-ын ажилтанд онгоц булаах үед мөрдөх журмын талаар ойлголт өгөх;
- (7) Аюулгүйн хамгаалалтын явган болон хөдөлгөөнт эргүүл: Үнэлгээ - 4, НАХ-ын ажилтанд урьдчилан сэргийлэх явган болон хөдөлгөөнт эргүүл, аюулгүйн хамгаалалтын зөрчлийн хариу үйлдлийн талаарх бүх талын мэдлэгийг олгох;
- (8) Аэродром дээрх хөдөлгөөн: Үнэлгээ - 5, НАХ-ын ажилтанд тухайн аэродром дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нарийвчилсан журмыг заах;
- (9) Нисэхийн радио-холбооны үйл ажиллагаа болон журам: Үнэлгээ - 4, НАХ-ын ажилтанд хязгаарлагдмал радио-холбооны операторын гэрчилгээний стандартын дагуу зөв радио-холбооны сахилга батын талаар заах;
- (10) Заналхийллийн хүчин зүйл: Үнэлгээ - 2, НАХ-ын ажилтанд алан хядах ажиллагаа болон гэмт хэргийн өнөөгийн хандлагын талаар шинэчилсэн мэдээлэл өгөх;
- (11) Зэвсэг: Үнэлгээ - 3, НАХ-ын ажилтанд нислэгийн өмнөх аюулгүйн үзлэгийн үеэр олон төрлийн галт зэвсэг болон түүнтэй төстэй зэвсгийг таньж тогтооход нь туслах зорилгоор мэдлэг олгох;
- (12) Хууль бус үйлдлийн түүхэн баримт болон статистик: Үнэлгээ - 2, НАХ-ын ажилтанд нисэхийн аюулгүйн хамгаалалтын түүхэн хөгжил болон хэрэг явдлын тархцын талаар мэдлэг олгох;
- (13) Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагын талаарх баримт мэдээлэл: Үнэлгээ - 1, НАХ-ын ажилтанд ICAO, Конвенцийн, Хавсралт 17 болон түүнтэй холбоотой Doc 8973-

- 4/ Тэсэрч дэлбэрэх бодис илрүүлэх аппарат: нисэх буудал, агаарын хөлөг, эсхүл зорчигчийн үзлэгийн цэгт суурилуулсан тэсэрч дэлбэрэх бодис илрүүлэх аппараттай танилцах, ашиглалтын дадлага хийх /үнэлгээ 3/;
- 5/ Зэвсэглэсэн этгээдтэй тэмцэх: зэвсэглэсэн этгээдийг саатуулах болон бусад хүмүүсийг тухайн заналхийллээс хамгаалах /үнэлгээ 3/;
- 6/ Агаарын хөлгийг булаах үед авах хариу арга хэмжээний горим: агаарын хөлгийг булаах үед авах хариу арга хэмжээний журам, ойлголт /үнэлгээ 2/;
- 7/ Явган болон хөдөлгөөнт эргүүл: явган болон хөдөлгөөнт эргүүлийн үйл ажиллагаатай танилцах ба аюулгүй байдлын зөрчлийн үед хариу арга хэмжээ авах /үнэлгээ 4/;
- 8/ Аэродромын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн: аэродромын талбайд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дүрэмтэй танилцах /үнэлгээ 5/;
- 9/ Агаарын навигацын радио-телефон холбооны үйл ажиллагаа, ажиллах горим: радио-телефон холбооны операторын гэрчилгээ авах хэмжээнд радио холбооны зарчимд сургах /үнэлгээ 4/;
- 10/ Заналхийллийн элемент: алан хядах үйл ажиллагаа болон гэмт хэргийн хандлагын талаар мэдээлэл өгөх /үнэлгээ 2/;
- 11/ Галт зэвсэг: төрөл бүрийн галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгсэлтэй танилцах /үнэлгээ 3/;
- 12/ Хөндлөнгийн хууль бус үйлдлийн түүхэн болон статистик мэдээ: нисэхийн аюулгүй байдлын дэвшилтэт үйл ажиллагааны талаар мэдлэг олгох /үнэлгээ 2/;
- 13/ Олон улсын стандарт, заавар, журмын талаарх мэдээлэл: Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан Чикагогийн конвенцийн Хавсралт 17 болон Doc 8973-тай

Орчуулга,
найруулга зассан

ыг танилцуулах.

А.24. Давтан сорилт хийх

- (a) НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь НАХ-ын ажилтанд урьдчилан мэдэгдэлгүйгээр, стандарт сорилын биет ашиглан сорилт хийдэг болохыг бататгах үүрэгтэй.
- (b) Сорилтыг, аюулгүйн үзлэгийн үйл ажиллагааны бүрэн бүтэн байдалд үнэлгээ өгөх зорилгоор хийх ба тухайн сорилтод орж байгаа НАХ-ын ажилтанд стандарт сорилын биетийг илрүүлэх боломжийг олгох хэлбэрээр зохион байгуулах ёстой.
- (c) Даргын хүлээн зөвшөөрөхүйц байхаас бусад тохиолдолд тухайн стандарт сорилын биетийг давтан сорилтод ашиглахыг зөвшөөрөхгүй.
- (d) Стандарт сорилын биет нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
- (1) зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг төлөөлдөг байх;
- (2) үйл ажиллагааны бодит нөхцөлд ашиглагддаг байх.
- (e) Сорилтод орж байгаа, эсхүл давтан сорилтод орж байгаа НАХ-ын ажилтны ур чадварыг тодорхойлохдоо дараах хэмжүүрийг ашиглах ёстой:
- (1) хэрэв сорилтын явцад стандарт сорилын биет бүрийг илрүүлсэн бол, сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан тухайн шаардсан стандартыг хангаж байна гэж үзнэ;
- (2) хэрэв энэ зүйлийн (f) - (k)-ийн дагуу хийгдэж байгаа сорилтын явцад стандарт сорилын биетийг илрүүлээгүй бол, сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан тухайн шаардсан стандартыг хангаагүй гэж үзэн дараах арга

холбоотой гарсан бусад заавруудтай танилцах /үнэлгээ 1/.

А 24. Шалгалт /тест/ авах

- (a) Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь аюулгүй байдлын ажилтанд урьдчилж мэдэгдэлгүйгээр стандарт тестийг ашиглаж шалгалт авна.
- (b) Аюулгүй байдлын үзлэгийн журмыг үнэлэх болон аюулгүй байдлын ажилтан "стандарт тест"-ийг илрүүлэх чадвартай эсэхийг тогтооно.
- (в) "Стандарт тест" нь:
- (i) хориглосон зүйл; мөн
- (ii) бодит нөхцөл байдалд хэрэглэгдэж буй зүйл байж болно.
- (г) Аюулгүй байдлын ажилтнаас мэргэжлийн шалгалт, давтан шалгалтыг дараах аргаар авна:
- 1/ шалгалтын явцад энэ хэсгийн (в)-гийн (i), (ii)-т дурьдсан "стандарт тест" бүрийг илрүүлсэн ажилтныг шаардлага хангасан гэж үзэх;
- 2/ энэ хэсгийн (д)-гээс (з)-д заасан шалгалтын явцад "стандарт тест"-ийг илрүүлж чадаагүй ажилтныг шаардлага хангаагүй гэж үзэн дараах арга хэмжээг авна:
- (i) давтан шалгалт авах;
- (ii) давтан шалгалтыг амжилттай өгөх хүртэл үүрэгт ажлаас нь түр түдгэлзүүлэх;
- 3/ давтан шалгалтаар "стандарт тест"-ийг илрүүлээгүй тохиолдолд:
- (i) шалгалт авч буй этгээд нь байгууллагын удирдлагад мэдэгдэнэ;
- (ii) байгууллагын удирдлага нь шалгалтад хангалтгүй дүн үзүүлсэн ажилтнуудыг холбогдох сургалтад хамруулах ба тухайн ажилтнаас давтан шалгалт авч шаардлага хангасан тохиолдолд ажил үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл олгоно.
- (д) Гэрчилгээ эзэмшигч нь металл илрүүлэгч багаж хэрэгслийн шалгалтын үед дараах зүйлийг анхаарна:
- 1/ Шалгалт авч буй этгээд нь "стандарт тест"-ийг ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн газраа нуусан байна;
- 2/ шалгалт авч буй этгээд нь:

-Орчуулга,
найруулга зассан

хэмжээг авах ёстой:

- (i) давтан сорилтод хамруулах;
- (ii) давтан сорилтыг амжилттай өгөх хүртэл тухайн ажил үүргээс нь чөлөөлдөг байх;

(3) хэрэв давтан сорилтоор стандарт сорилын биетийг илрүүлээгүй бол:

- (i) сорилт хийж байгаа шалгагч нь аюулгүйн хамгаалалтын удирдах ажилтанд мэдэгдэх үүрэгтэй;
- (ii) аюулгүйн хамгаалалтын удирдах ажилтан нь тухайн алдааны бүртгэлийг хөтлөх үүрэгтэй;
- (iii) аюулгүйн хамгаалалтын удирдах ажилтан нь, сорилтод тэнцээгүй НАХ-ын ажилтан бүрийг залруулах давтан сургалтад хамруулах ба дахин ажил үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрөхийн өмнө, ажилтныг тухайн даалгаврын стандартыг хангаж чадахыг харуулах сорилтод хамруулах үүрэгтэй.

(f) Гэрчилгээ эзэмшигч нь, металл илрүүлэгчийн сорилт хийгдэж байх үед дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

- (1) сорилт хийж байгаа шалгагч нь стандарт сорилын биетийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр сорилын тээгчид нуудаг байх;
- (2) тухайн сорилын тээгчийг дараах байдлаар нэвтрүүлдэг байх:

- (i) хэрэв илрүүлэгч нь металл илрүүлэгч хаалга бол, ердийн алхах хурдаар зорчигчийн урсгалын чиглэлд металл илрүүлэгч хаалгаар; эсхүл
- (ii) тээврийн хэрэгсэлд суусан, эсхүл ачигдсан байдлаар;

(3) металл илрүүлэгч хаалганы дохиолол ажилласан бол, тухайн шалгагч нь сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан гар-металл илрүүлэгч ашиглан, эсхүл биед нь шалгалт хийн, стандарт сорилын биетийг таньж илрүүлж байгаа эсэхийг тогтоодог байх;

(4) гар-металл илрүүлэгчийн дохиолол ажилласан үед, тухайн шалгагч нь сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан стандарт сорилын биетийг таньж илрүүлж байгаа эсэхийг тогтоодог байх;

(5) хэрэв стандарт сорилын биет ойртоход металл илрүүлэгч

- (i) хэрэв металл илрүүлэгч хаалгыг шалгах бол тухайн хаалгаар өөрөө зорчигчийн нэг адил нэвтэрч шалгана;
- (ii) суугаа байдлаар нэвтэрч шалгана.

3/ металл илрүүлэгч хаалга дохио өгсөн тохиолдолд шалгалт авч буй этгээд нь "стандарт тест"-ийг илрүүлэх зорилгоор аюулгүй байдлын ажилтныг металл илрүүлэгч гар багаж ашиглах, эсхүл гараар үзлэг хийх эсэхийг тодорхойлно;

4/ металл илрүүлэгч гар багажны дохио ажилласан үед шалгагч аюулгүй байдлын ажилтныг "стандарт тест"-ийн байрлалыг илрүүлсэнд тооцно;

5/ "стандарт тест"-ийг ашиглах шалгалтын үед металл илрүүлэгч хаалга болон гар багажны дохио ажиллаагүй бол:

- (i) шалгалт авч буй этгээд байгууллагын удирдлагад энэ талаар мэдэгдэнэ;
- (ii) тухайн металл илрүүлэгчийг ашиглалтын шаардлага хангатай үйлчилгээнд хэрэглэхгүй.

(e) Шалгалт авч буй этгээд нь рентген туяаны аппарат дээр шалгалт авахдаа дараах арга хэмжээг авна:

1/ "стандарт тест"-ийг бусад зүйлийн хамт үзлэг хийсэн цүнхэнд хийнэ;

2/ аюулгүй байдлын ажилтан тухайн "стандарт тест"-ийг дэлгэцэн дээр таньж байгаа эсэх, мөн түүнийг гараар илрүүлж чадах эсэхийг тодорхойлно;

3/ рентген туяаны аппаратны дэлгэцэн дээр танигдаагүй зүйлийг аюулгүй байдлын ажилтан гараар илрүүлж чадах эсэхийг тогтоох;

-Орчуулга,
найруулга зассан

хаалганы, эсхүл гар-металл илрүүлэгчийн дохиолол ажиллаагүй бол:

(i) тухайн төхөөрөмжид алдаа байгаа талаар шалгагч аюулгүйн хамгаалалтын удирдах ажилтанд мэдэгддэг байх;

(ii) үйл ажиллагааны стандартыг хангах хүртэл тухайн металл илрүүлэгчийг үйлчилгээнээс гаргадаг байх.

(g) Гэрчилгээ эзэмшигч нь, рентген төхөөрөмжид сорилт хийгдэж байгаа үед сорилт хийж байгаа шалгагч дараах шаардлагыг хангадаг болохыг бататгах үүрэгтэй:

(1) тухайн стандарт сорилын биетийг аюулгүйн үзлэг хийгдэж байгаа цүнх саванд бусад эд зүйлийн хамт байрлуулдаг байх;

(2) сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан стандарт сорилын биетийг рентген төхөөрөмжийн дэлгэцэн дээр таньж, гар шалгалтаар стандарт сорилын биетийг илрүүлж чадаж байгаа эсэхийг тогтоодог байх;

(3) тухайн агууламж нь рентген төхөөрөмжийн дэлгэцэн дээр зөв танигдахгүй байгаа үед НАХ-ын ажилтан нь гар шалгалт хийх хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлох шийдвэр гаргах чадварт үнэлгээ хийдэг байх.

(h) Гар шалгалтын сорилт хийгдэж байгаа үед гэрчилгээ эзэмшигч нь, сорилт хийж байгаа шалгагч дараах шаардлагыг хангадаг болохыг бататгах үүрэгтэй:

(1) тухайн стандарт сорилын биетийг аюулгүйн үзлэг хийгдэж байгаа цүнх саванд бусад эд зүйлийн дунд нуудаг байх;

(2) сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан стандарт сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тогтоодог байх.

(i) Үзлэгийн дараах бүсэд сорилт хийгдэж байгаа үед гэрчилгээ эзэмшигч нь, сорилт хийж байгаа шалгагч дараах шаардлага хангадаг болохыг бататгах үүрэгтэй:

(1) үзлэгийн дараах бүсийг шалгахын өмнө стандарт сорилын биетийг тухайн бүсэд нуудаг байх;

(2) сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан тухайн стандарт сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тогтоодог байх.

(j) Агаарын хөлгийг шалгах сорилт хийгдэж байгаа үед гэрчилгээ эзэмшигч нь, сорилт хийж байгаа шалгагч дараах шаардлага хангадаг болохыг бататгах үүрэгтэй:

(1) зорчигч ердийн үед нэвтэрч болох тухайн агаарын хөлгийн аливаа хэсэгт стандарт сорилын биет нуудаг байх;

(2) сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан тухайн стандарт

(ж) Гараар хийх үзлэгийн үед шалгагч аюулгүй байдлын ажилтнаас дараах шалгалт авсан эсэхийг Гэрчилгээ эзэмшигч хянана:

1/ үзлэгээр орсон цүнхэнд хийсэн "стандарт тест"-ийг гараар илрүүлэх;

2/ тухайн "стандарт тест"-ийн байрлалыг тогтоох.

(з) Гэрчилгээ эзэмшигч нь үзлэгийн дараахь бүсэд шалгалт хийсний дараа шалгагч аюулгүй байдлын ажилтнаас дараах тест авсан эсэхийг хянана:

1/ үзлэгийн дараахь бүсийг шалгах агаарын хөлгөөс өмнө "стандарт тест"-ийг тухайн бүсэд нуух

2/ аюулгүй байдлын ажилтан тухайн "стандарт тест"-ийн байрлалыг тогтоох.

(и) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлөгт шалгалт хийсний дараа шалгагч аюулгүй байдлын ажилтнаас дараах тест авсан эсэхийг хянана:

1/ агаарын хөлгийн зорчигч нэвтрэх хэсэгт байрлуулсан "стандарт тест"-ийг нуух

2/ аюулгүй байдлын ажилтан тухайн "стандарт тест"-ийн байрлалыг тогтоох.

(к) Гэрчилгээ эзэмшигч нь тээврийн хэрэгсэлд шалгалт хийсний дараа шалгагч аюулгүй байдлын ажилтнаас дараах тест авсан эсэхийг хянана:

1/ "стандарт тест"-ийг тээврийн хэрэгслийн аль нэг хэсэгт нуух;

2/ аюулгүй байдлын ажилтан тухайн "стандарт тест"-ийн

<p>сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тогтоодог байх.</p> <p>(к) Гэрчилгээ эзэмшигч нь тээврийн хэрэгслийн шалгалтын сорилт хийгдэж байгаа бол, тухайн шалгагч дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:</p> <p>(1)тээврийн хэрэгслийн аливаа хэсэгт стандарт сорилын биетийг нуудаг байх;</p> <p>(2)сорилтод орж байгаа НАХ-ын ажилтан тухайн стандарт сорилын биетийг илрүүлсэн эсэхийг тогтоодог байх.</p>	<p>байрлалыг тогтоох.</p>	
<p><u>A.25. Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс</u> <u>Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн үзлэгийн цэг болон төхөөрөмж</u></p> <p><u>(a)Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан болохыг бататгах үүрэгтэй:</u></p> <p><u>(1)өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс рүү нэвтэрч байгаа эсхүл тухайн бүсэд байгаа хүмүүс, эд зүйл, бодис болон тээврийн хэрэгсэлд Даргын баталсан тусгай арга хэлбэр, эсхүл аргачлалын дагуу аюулгүйн үзлэг, эсхүл шалгалт хийдэг байх;</u></p> <p><u>(2)өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс рүү нэвтэрч байгаа эсхүл тухайн бүсэд байгаа хүмүүс, тэдэнтэй холбоотой эд зүйл, бодис болон тээврийн хэрэгслийг оролцуулан аюулгүйн үзлэг, эсхүл шалгалтыг Сайдын, эсхүл Даргын шаардсаны дагуу хийдэг байх;</u></p> <p><u>(3)Даргын баталсан тусгай арга хэлбэр, эсхүл аргачлалын дагуу аюулгүйн үзлэг болон шалгалтыг хийх хангалттай тооны ажилтан болон төхөөрөмжтэй байх;</u></p> <p><u>(4)түүний НАХ-ын ажилтан нь, аюулгүйн үзлэгийн төхөөрөмжийг чадварлагаар шалгадаг болохыг бататгах зорилгоор стандарт сорилын биетийг ашиглах зааварчилгаа авдаг байх;</u></p> <p><u>(5)өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн аюулгүйн үзлэгийн цэгт ашиглаж байгаа аюулгүйн үзлэгийн аппаратад Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр сорилт хийдэг байх.</u></p> <p><u>Хүмүүс, эд зүйл, бодис болон тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэг хийх</u></p> <p><u>(b) Гэрчилгээ эзэмшигч нь аюулгүйн үзлэг хийхдээ дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</u></p> <p><u>(1)аюулгүйн үзлэг болон шалгалт хийгдэж байгаа цэг бүрд, аливаа этгээд өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэхээс өмнө аюулгүйн үзлэгээр заавал орохыг анхааруулсан дараах мэдээллийг байрлуулсан байх:</u></p> <p><u>(i) аливаа этгээд, эсхүл эд зүйл, бодис, эсхүл тухайн этгээдийн хяналтад байгаа тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэгийг зөвхөн тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгээр</u></p>		<p>-Amend.5-аар нэмэгдсэн</p>

хийх;

(ii) аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан этгээдийг тухайн цэгээр нэвтрүүлдэггүй байх;

(2) хэрэв аюулгүйн үзлэгийг өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд хийж байгаа бол аюулгүйн үзлэг хийгдэх этгээдэд дараах шаардлагыг мэдэгдсэн байх:

(i) аливаа этгээд, эсхүл эд зүйл, бодис, эсхүл тухайн этгээдийн хяналтад байгаа тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэгийг зөвхөн тухайн этгээдийн зөвшөөрөлтэй хийдэг байх;

(ii) аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан этгээдийг тухайн өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийг орхин гарахыг шаарддаг байх;

(3) Даргын баталсан тусгай арга хэлбэр, эсхүл аргачлалын дагуу дараах бүртгэл хөтөлдөг болохыг бататгасан байх:

(i) тухайн аюулгүйн үзлэгийн арга;

(ii) Сайдын, эсхүл Даргын шаардсан, аюулгүйн үзлэгийн үргэлжлэх хугацаа;

(iii) аюулгүйн үзлэгт хамрагдсан хүмүүс, эд зүйл, бодис болон тээврийн хэрэгслийн тоо;

(4) хэрэв зөвшөөрөгдөөгүй эд зүйл илэрсэн бол, дараах бүртгэл хөтөлдөг болохыг бататгасан байх:

(i) аюулгүйн үзлэг хийсэн ажилтны нэр;

(ii) илэрсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйл;

(iii) зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг аюулгүй болгох арга хэмжээ.

(c) Аюулгүйн үзлэгийн явцад, гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

(1) түүний НАХ-ын ажилтан нь аливаа этгээд, эд зүйл, бодис, эсхүл тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэг хийхдээ, тухайн этгээд аливаа зөвшөөрөгдөөгүй эд зүйл тээвэрлээгүй, эсхүл биедээ авч яваагүй болохыг бататгах;

(2) түүний НАХ-ын ажилтан, зөвшөөрөгдөөгүй эд зүйл биедээ авч явсан нь илэрсэн этгээдийг өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэхийг зөвшөөрдөггүй болохыг бататгах;

(3) түүний НАХ-ын ажилтан, зөвшөөрөгдөөгүй эд зүйл биедээ авч явсан нь илэрсэн этгээдийг өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийг орхихыг шаарддаг болохыг бататгах;

(4) дараах шаардлагыг бататгах зорилгоор, сорилт, эсхүл шалгалтын үр дүнгийн бүртгэл хөтөлдөг болохыг:

(i) аюулгүйн үзлэгийн үнэн зөв байдлыг бататгах зорилгоор 28 хоног тутамд шалгах;

-Amend.5-аар
НЭМЭГДСЭН

(ii) аюулгүйн үзлэг гүйцэтгэж байгаа НАХ-ын ажилтнуудын үр чадварыг Хавсралт А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу 150 хоног тутамд шалгах.

Эд зүйл, эсхүл бодисыг гараар шалгах

(d) Гэрчилгээ эзэмшигч, хэрэв эд зүйл, эсхүл бодист тэсрэх хэрэгсэл агуулагдсан гэж сэжиглэх шалтгаан байгаа бол, эсхүл сэжигтэй тэсрэх хэрэгсэл илэрсэн бол, түүний НАХ-ын ажилтан нь Хавсралт А.11(b)(5)-д шаардсан журмыг мөрддөг болохыг бататгах үүрэгтэй.

(e) Гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг бататгах зорилгоор, сорилт, эсхүл шалгалт хийж, тэдгээрийн үр дүнгийн бүртгэл хөтлөх үүрэгтэй:

(1) гар шалгалтын үнэн зөв байдлыг 28 хоног тутамд хийдэг байх;

(2) гар шалгалт гүйцэтгэж байгаа НАХ-ын ажилтнуудын үр чадварыг Хавсралт А.24-т заасан давтан сорилт хийх шаардлагын дагуу 150 хоног тутамд авдаг байх.

А.26. Аюулгүйн хамгаалалттай холбоотой хориг (шилжилт)

ИНД-91.9-ийн дагуу Дарга эрх олгосноос бусад тохиолдолд, аливаа этгээдийг аюулгүйн хамгаалалтын хяналтаар орсон этгээдэд дараах зүйлийг дамжуулах, эсхүл түүнийг аюулгүйн хамгаалалтын хяналт хийгдсэн агаарын хөлгийн бүхээгт байгаа этгээд авах боломжтой байрлалд тавихыг хориглоно:

(1) галт зэвсэг;

(2) аюултай, эсхүл хор хөнөөл үчрүүлэх зэвсэг, эсхүл бусад төрлийн хэрэглэл;

(3) сүм хэрэгсэл;

(4) тэсрэх бодис, эсхүл хэрэгсэл, эсхүл гэмтэл үчрүүлэх бодис, эсхүл агаарын хөлгийн, эсхүл агаарын хөлгийн бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд аюул үчрүүлэхэд ашиглаж болох бусад төрлийн хэрэгсэл.

А.27. Хориглох зүйл (шилжилт)

Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр, аливаа этгээд нь дараах үйлдэл хийхгүй байх үүрэгтэй:

(1) аюулгүйн хамгаалалттай бүс, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл үйл ажиллагааны бүсэд нэвтрэх боломжийг хянах зорилгоор хийсэн хаалга, хашаа, эсхүл аэродромын бусад хаалт, хашааг нээлттэй, эсхүл хамгаалалтгүй, эсхүл бусад хэлбэрээр хяналтгүй үлдээх; эсхүл

(2) аюулгүйн хамгаалалттай бүс, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл үйл ажиллагааны бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэхэд ашиглагдаж байгаа

Хавсралт 1

ХОРИГЛОСОН АЮУЛТАЙ БОДИС БА ЭД ЗҮЙЛСИЙН ЖАГСААЛТ

- Part 19-өөс шилжүүлсэн

хашаа, хаалт, эсхүл бусад зүйлийн дэргэд, эсхүл дээр нь хяналтын арга хэмжээнээс зайлсхийх боломж олгох зорилгоор, аливаа эд зүйлийг урьдчилан байрлуулах, тавих, эсхүл үлдээх.

A.28. Нисэх буудлын нэвтрэх үнэмлэх (шилжилт)

(a) Дарга дараах тохиолдолд, нисэх буудлын нэвтрэх үнэмлэх, эсхүл бусад нэвтрэх баримт бичгийг энэ дүрмийн дагуу олгож, эсхүл зөвшөөрч болно, хэрэв:

(1) үнэмлэх, эсхүл баримт бичиг авах хүсэлт гаргасан этгээдийг тодорхойлох аюулгүйн хамгаалалтын зохих шалгалтыг Хүүлийн дагуу хийсэн бол; эсхүл

(2) тухайн этгээдийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүйн хамгаалалтын дүйцэх өөр шалгалтад тэнцсэн гэж үзсэн бол.

(b) Энэ зүйлийн (c), (g)-г харгалзан, дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээдийг аэродром, эсхүл навигацийн байгууламжийн аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх, эсхүл тухайн бүсэд үлдэхийг зөвшөөрөхгүй:

(1) нисэх буудлын нэвтрэх үнэмлэхийг хувцасны гадна энгэрт, ил харагдахаар зүүсэн бол; эсхүл

(2) энэ зүйлийн (a)-ийн дагуу зөвшөөрсөн хугацаанд өөр нэвтрэх баримт бичиг, эсхүл бусад нэвтрэх баримт бичгийг биедээ авч яваа бол.

(c) Дарга, нисэх буудлын нэвтрэх үнэмлэх эзэмшигчийн нэрийг ил болгохгүй байх нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд, үнэмлэх эзэмшигчийн нэр заагаагүй нэвтрэх үнэмлэх зүүхийг зөвшөөрч болно.

(d) Энэ дүрмийн дагуу аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгогдсон этгээд нь зөвхөн ажил үүргээ гүйцэтгэх зорилгоор тухайн бүсэд үлдэж болно.

(e) Хэрэв эрх бүхий этгээд шаардвал, аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх этгээд нь нисэх буудлын нэвтрэх үнэмлэх, эсхүл энэ зүйлийн (a)-ийн дагуу эрх олгосон бусад нэвтрэх баримт бичгийг шалгуулах үүрэгтэй.

(f) Хэрэв нисэх буудлын нэвтрэх үнэмлэх эзэмшигч нь үнэмлэх шаардлагатай ажлын байранд ажиллахаа больсон, эсхүл бусад шалтгаанаар үнэмлэх эзэмших эрхгүй болсон бол үнэмлэх олгосон эрх бүхий байгууллагад үнэмлэхээ нэн даруй буцаан өгнө.

(g) Энэ зүйлийн (b) нь дараах этгээдэд хамаарахгүй:

(1) тухайн этгээд байнга оршин суудаг улсын засгийн газрын эрх бүхий байгууллагын, эсхүл ажил олгогчийн олгосон албан

ёсны нэвтрэх үнэмлэхийг хувцасны гадна талд зүүсэн, олон улсын үйлчилгээний агаарын хөлгийн багийн гишүүнд; эсхүл (2) албан ажлын шаардлагаар нууцлагдмал байх шаардлагатай Монгол Улсын засгийн газрын агентлагийн албан тушаалтанд; эсхүл

(3) хэрэв аливаа этгээд нь тухайн нислэгийн хүчинтэй суугчийн тасалбартай, эсхүл багийн гишүүн, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчийн төлөөлөгч түүнийг дагалдаж яваа бол нислэгээр явах, эсхүл нислэгээс бүүх зорилгоор аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх, эсхүл бүсээс гарах зорчигчид; эсхүл

(4) хэрэв тухайн хөлгийн дарга нисгэгчийн хүчинтэй үнэмлэхээ биедээ авч яваа бол, агаарын хөлөгт суух, бүүх, эсхүл үйлчилгээ хийх зорилгоор аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд байгаа, эсхүл түүнд нэвтрэх хувийн нислэг үйлдэх агаарын хөлгийн даргад, болон тухайн агаарын хөлгийн даргын дагуулж яваа аливаа этгээдэд.

(h) Хэрэв нэвтрэх үнэмлэх авах хүсэлт гаргасан этгээдэд Дарга аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх болон үлдэхийг зөвшөөрсөн түр нэвтрэх үнэмлэх олгосон ба түүнийг Хавсралт А.28(а)(1), (2)-т заасны дагуу аюулгүйн хамгаалалтын шалгалтын үйл явцын дагуу олгосон нисэх бүүдлын нэвтрэх үнэмлэхтэй этгээд дагалдаж байгаа бол тухайн этгээдэд Хавсралт А.28(а)(1), (2)-т заасан аюулгүйн хамгаалалтын шалгалт хийхийг шаардахгүй.

--oOo--

Дүрмийн боловсруулалтын хэлтэс